

**FRIEDRICH
EBERT
STIFTUNG**

ХБНГУ-ын
Фридрих-Эбертийн сан

2020

ЦАР ТАХАЛ

КОВИД-19

Бичил бизнес эрхлэгчдэд ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Улаанбаатар хот



КОВИД-19 ЦАР ТАХАЛ: БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

Энэхүү судалгааны ажлыг Фридрих-Эбертийн сангийн захиалгаар хийж гүйцэтгэв. Судалгааны аливаа агуулга, мэдээллийн үнэн зөвийг судлаачид хариуцах бөгөөд Фридрих-Эбертийн сангийн байр суурьд нийцэж байх албагүй болно.

Судалгааг хийж гүйцэтгэсэн:



МЭДЛЭГИЙН
ХОТХОН ТББ

Мэдлэгийн хотхон НҮТББ

Ахлах судлаачид:

Л.Сарангэрэл
Г.Даваадулам
Б.Бадамгарав
Ц.Заяхүү

Эхийг бэлтгэсэн

Ё.Батболд

©ХБНГУ-ын Фридрих-Эбертийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас эрхлэн гаргав. Уг бүтээлийн эрх хуулийн дагуу хамгаалагдсан тул зөвшөөрөлгүйгээр болон эшлэлгүйгээр хуулбарлах, олшруулах, хэсэгчлэн авах, ашиглах, арилжааны зориулалтаар хэвлэн нийтлэхийг зохиогчийн эрх зөрчсөнд тооцно.

ISBN 978-9919-9527-7-8

“Эдмаркет” Хэвлэлийн газар

КОВИД-19 ЦАР ТАХАЛ:
БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДЭД
ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	6
ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРАГ.	7
НЭГ.СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	9
1.1 Судалгааны ажил хийх Үндэслэл	9
1.2 Судалгааны ажлын Зорилго	9
1.3 Судалгааны ажлын Хамрах хүрээ	9
1.4 Судалгааны ажлын Аргачлал	9
ХОЁР.СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА	13
2.1 Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс нийгэм, эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр	13
2.2 Монгол Улсын эдийн засаг: Коронавирус халдварт цар тахлаас өмнөх ба одоо үеийн эдийн засгийн харьцуулалт	20
ГУРАВ.СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН, АНХААРАХ АСУУДЛУУД	31
3.1 Бичил бизнес эрхлэгчид (Худалдааны салбарт)	31
3.2 Бичил Бизнес Эрхлэгчдийн Орчин нөхцөл, Үйл ажиллагааны чиглэл	31
3.3 Бичил Бизнес Эрхлэгчдийн Орлого, Нийгмийн үйлчилгээ, Зээл тусламж	38
3.4 Засгийн Газрын Хэрэгжүүлж буй бодлого шийдвэр	47
3.5 Иргэдийн Амьдралд Тулгарч буй Хүндрэл Бэрхшээл	50
3.6 Судалгаанд оролцогчдын Ерөнхий мэдээлэл	51
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	53
ТАВ. ЗӨВЛӨМЖ	55
ХАВСРАЛТ	57

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АБС	Албан бус Сектор
ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГШХО	Гадаадын Шууд Хөрөнгө Оруулалт
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн байгууллага
МБ	Монгол Банк
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан татвар
НЗДТГ	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар
ОБЕГ	Онцгой Байдлын Ерөнхий Газар
ОХУ	Оросын Холбооны Улс
ЗГ	Засгийн Газар
УИХ	Улсын Их Хурал
ҮАБЗ	Үндэсний Аюулгүй Байдлын зөвлөл
ХНБГУ, ФЭС	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Фридрих-Эбертийн сан
ЖДҮ	Жижиг Дунд Үйлдвэрлэл
ТЕГ	Татварын Ерөнхий Газар
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо

ХҮСНЭГТ, ГРАФИК, ЗУРАГ

ХҮСНЭГТ 1.1	БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ	10
ХҮСНЭГТ 1.2	ЭКСПЕРТИЙН ЯРИЛЦЛАГА АВАХ ОРОЛЦОГЧДЫН ТҮҮВЭРЛЭЛТ	10
ХҮСНЭГТ 1.3	ТООН СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТҮҮВЭРЛЭЛТ, ХЭМЖЭЭ	11
ХҮСНЭГТ 2.1	КОРОНАВИРУС ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ЗГ-ЫН ТОГТООЛ	14
ХҮСНЭГТ 2.2.	ГАДААД ХУДАЛДААНЫ ГҮЙЦЭТГЭЛ (САЯ АМ.ДОЛЛАР)	23
ХҮСНЭГТ 2.3.	ИМПОРТЫН ГҮЙЦЭТГЭЛ (САЯ АМ.ДОЛЛАР)	24
ХҮСНЭГТ 2.4.	ЭКСПОРТЫН ГҮЙЦЭТГЭЛ (САЯ АМ.ДОЛЛАР)	26
ХҮСНЭГТ 3.1	АЛБАН БУС СЕКТОРТ АЖИЛЛАГСДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА	32
ХҮСНЭГТ 3.2	ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУДААС ХАМГИЙН ОНОВЧТОЙ ГЭСЭН ШИЙДВЭРҮҮДИЙГ ДЭМЖИЖ БУЙ БАЙДАЛ	48
ГРАФИК 1.1	УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЛБАН БУС СЕКТОРЫН ТОО (ДҮҮРЭГ ТУС БҮРЭЭР)	11
ГРАФИК 2.1	МОНГОЛ УЛСЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛИЙГ СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН БАЙДЛААР АВЧ ҮЗВЭЛ	21
ГРАФИК 2.2	МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО	22
ГРАФИК 2.3	2019 ОНЫ ЭКСПОРТ, ИМПОРТЫН БҮТЭЦ, УЛС ОРНООР ХАРУУЛБАЛ	30
ГРАФИК 3.1	СУДАЛГААНЫ ТҮҮВЭРТ ХАМРАГДСАН АЛБАН БУС СЕКТОРУУД, БҮЛГЭЭР, ТООГООР	31
ГРАФИК 3.2	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭН ЯВУУЛЖ БУЙ ЧИГЛЭЛ	32
ГРАФИК 3.3	ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭРХЭЛЖ БАЙГАА ХУГАЦАА	33
ГРАФИК 3.4	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭН ЯВУУЛЖ БУЙ ГАЗАР ОРЧНЫ ШААРДЛАГА, СТАНДАРТЫГ ХАНГАСАН БАЙДАЛ	34
ГРАФИК 3.5	ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ГАЗРЫН ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР?	36
ГРАФИК 3.6	ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ ХЭД ВЭ?	36
ГРАФИК 3.7	КОРОНАВИРУС ГАРСНААС ХОЙШ ТҮРЭЭСИЙН ЗАРДЛЫГ ЯМАР НЭГЭН БАЙДЛААР БУУРСАН ЭСЭХ	37
ГРАФИК 3.8	КОРОНАВИРУС ЦАР ТАХАЛ ГАРСНААС ХОЙШ ИРГЭДИЙН ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРТ ЯМАР НӨЛӨӨ ГАРСАН БЭ?	39
ГРАФИК 3.9	КОРОНАВИРУС ЦАР ТАХЛААС ҮҮДЭН МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨНДӨРЖҮҮЛСЭН БАЙДАЛД ШИЛЖСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН МОНГОЛ УЛС ӨӨРИЙН БҮХ ХИЛЭЭ ХААСАН. ҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ТАНЫ ЭРХЭЛЖ БАЙГАА БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЯМАР ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ УЧИРЧ БАЙНА ВЭ?	40
ГРАФИК 3.10	ТА ӨӨРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ НИЙЛҮҮЛТЭЭ ХААНААС ХИЙДЭГ ВЭ?	40

ГРАФИК 3.11	КОРОНАВИРУС ГАРСНААС ХОЙШ БАРААНЫ ТӨРӨЛ, ЗҮЙЛД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН УУ?	41
ГРАФИК 3.12	НИЙГМИЙН ДААТГАЛ ТӨЛДӨГ ЭСЭХ	42
ГРАФИК 3.13	ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР ТӨЛДӨГ ЭСЭХ	43
ГРАФИК 3.14	БИЗНЕСИЙНХЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАХ ГЭЖ ЗЭЭЛ АВСАН БАЙДАЛ	43
ГРАФИК 3.15	ТА ХААНААС ЗЭЭЛ АВСАН БЭ?	44
ГРАФИК 3.16	ТАНЫ БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮ, ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЯМАР ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ БАЙНА ВЭ?	45
ГРАФИК 3.17	МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС КОРОНАВИРУС ЦАР ТАХЛААС ШАЛТГААЛАН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАХ, ДАВАН ТУУЛАХЫН ТУЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ ХЭР ҮР ДҮНТЭЙ БАЙНА ВЭ?	47
ГРАФИК 3.18	СҮҮЛИЙН 5 САРЫН ХУГАЦААНД ӨРХИЙН АМЬЖИРГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ	50
ГРАФИК 3.19	КОРОНАВИРУС ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛААС ШАЛТГААЛАН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРЭН ЗОГССОНТОЙ ХОЛБОГДУУЛАН АЖИЛ ЭРХЛЭГЧДЭД ҮҮСЧ БУЙ АЧААЛАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ ЯМАР БАЙНА ВЭ?	50
ГРАФИК 3.20	СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НАС	51
ГРАФИК 3.21	БОЛОВСРОЛЫН ТҮВШИН	52
ЗУРАГ		
ЗУРАГ 3.1	СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ХҮЙС	51

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1 Судалгааны Ажил Хийх Үндэслэл

БНХАУ-ын Хубэй мужийн Вухан хотод онош нь үл мэдэгдэх уушгины хатгалгаа гарсан нь ДЭМБ-ын Хятад улс дахь оффисд 2019 оны 12-р сарын 31-нд анх мэдээллэсэн. 2020 оны 1-р сарын 30-нд Олон Улсын Эрүүл Мэндийн Яаралтай Тусламжийн Байгууллагаас өвчний хурдацтай тархалтыг зарласан байна. Улмаар 3 сарын 11-нд ДЭМБ-аас Ковид-19-ийг цар тахал хэмээн зарласан.

Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл 2020 оны 1 сарын 30-ны өдөр хуралдаж, 01/01 дугаартай “Хилийн боомтыг түр хаах тухай” зөвлөмж гаргасан. 2020 оны 2 сарын 1-ний өдрөөс өнөөг хүртэл үе шаттайгаар Монгол Улсын иргэд БНХАУ-д зорчихыг хориглосон. Хорио цээрийн хугацаанд БНХАУ-аас орж ирэх бараа таваарын импорт, экспортыг хязгаарлаагүй байна.

ХБНГУ-ын Фридрих Эбертийн сангаас Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор улс орон даяар өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай холбоотойгоор хүнс, барааны томоохон худалдааны төвүүдэд үйл ажиллагаа эрхэлж буй бичил бизнес эрхлэгчдийн (Албан бус сектор буюу худалдаа, наймаа эрхлэгчид) орлогод гарсан өөрчлөлтөд дүн шинжилгээ хийх судалгааны ажил зарлаж сонгон шалгаруулалтын үр дүнд “Мэдлэгийн Хотхон” Нийгэмд үйлчлэх Төрийн бус байгууллага (цаашид Мэдлэгийн хотхон гэх) шалгарч, уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэж байна.

1.2 Судалгааны Ажлын Зорилго

Энэхүү судалгааны ажлын зорилго нь нэгдүгээрт Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагаануудын үр дүнг судлах, хоёрдугаарт бичил бизнес эрхлэгчдийн (худалдаа) орлогод гарсан өөрчлөлтөд дүн шинжилгээ хийхэд оршино.

1.3 Судалгааны ажлын хамрах хүрээ

Судалгааны ажлын хамрах хүрээг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд: Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс нийгэм, эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлж буй хууль, тогтоол, бодлого, шийдвэр Монгол Улсын эдийн засгийн байдал– Сүүлийн 3 жилээр Албан бус сектор (Худалдаа) үйл ажиллагаа эрхэлж буй иргэдийн тоо – Сүүлийн 3 жилээр Нийслэлийн хэмжээнд худалдааны салбарт ажиллаж буй албан бус сектор ажиллагсад

1.4 Судалгааны ажлын Аргачлал

Энэхүү судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд тоон болон чанарын хосолсон судалгааны аргачлалыг ашиглав. Үүнд:

Чанарын арга:

Баримт бичгийн судалгаа: Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлаас урьдчилсан сэргийлэх зорилгоор нийгэм, эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрүүд; хууль, тогтоол, Монгол Улсын эдийн засагт гарч буй өөрчлөлт, гадаад худалдааны эрэлт, нийлүүлэлтийн талаарх сүүлийн жилүүдийн статистик мэдээлэл; Албан

бус секторт ажиллагсдын ажлын байрны тогтвортой байдлыг судлах, дүн шинжилгээ хийх;

Сурвалжлага: Албан бус сектор буюу худалдааны салбарт ажиллагсдын төлөөллүүдээс ганцаарчилсан ярилцлага авах.

Тоон арга:

Тоон арга: Урьдчилан бэлтгэсэн асуумжын дагуу түүвэрт сонгогдсон нийслэлд үйл

ажиллагаа явуулж буй албан бус секторын төлөөллөөс анкет асуулга бөглүүлэх, дуу бичлэг хийх, талбарын зураг авалт хийх, цуглуулсан дата мэдээллийг SPSS 26 багц программаар нэгтгэн, мэдээллийг харьцаа, корреляци, дундаж бодох, хэв маягчилал үүсгэх, харьцуулах, нөлөөлөгч хүчин зүйлийн шинжилгээ хийх зэргээр анхдагч, хоёрдогч шинжилгээ хийсний үндсэн дээр дүнг нэгтгэн гаргана.

Судалгааны ажлын түүвэрлэлт, хэмжээ

ХҮСНЭГТ 1.1 БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГААНЫ ТҮҮВЭРЛЭЛТ

Түүврийн төлөөллийг дараах байдлаар тодорхойлов.

Баримт бичгүүд	Хаанаас	Хамрах хугацаа
Хууль, Тогтоол	УИХ	---
Бодлого, шийдвэр	ЗГ	---
Статистик тоон мэдээлэл	МБ СЯ ҮСХ	2016-2020

Чанарын судалгааны ганцаарчилсан ярилцлагад албан бус секторын төлөөллийг хамруулахыг зорьсон ба харин тоон аргаар явуулах судалгааны түүврийг квот болон санамсаргүй түүврийн аргад тулгуурлан хийнэ. Тоон судалгаанд Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж


буй томоохон худалдааны төв, захууд, хотын захын хороололд үйл ажиллагаа эрхэлж буй албан бус секторын төлөөллийг санамсаргүй түүврийн аргаар сонгон судлахаар урьдчилсан байдлаар тооцов.

ХҮСНЭГТ 1.2 ЭКСПЕРТИЙН ЯРИЛЦЛАГА АВАХ ОРОЛЦОГЧДЫН ТҮҮВЭРЛЭЛТ

№	Судалгаанд хамрагдах албан бус сектор	Судалгааны оролцогчид
	ТҮЦ	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
	Гутал, хувцас засвар	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
	Авто засвар	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
	Дугуй засвар	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
	Авто машин угаалга	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
	Жижиглэн худалдааны цэг	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
	Хүнсний чингэлэг	Хувиараа хөдөлмөр эрхлэгч

	Хүнсний бус чингэлэг	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
	Лангуу	Хувиараа хөдөлмөр эрхлэгч
	Дэлгүүр	Хувиараа хөдөлмөр эрхлэгч

ГРАФИК 1.1 УЛААНБААТАР ХОТОД ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БҮЙ АЛБАН БУС СЕКТОРЫН ТОО (ДҮҮРЭГ ТУС БҮРЭЭР)



Энэхүү үзүүлэлт нь Нийслэлийн нэгдсэн журмаар гаргасан тооллогын дүн статистикийн газраас гаргасан албан бус хараахан байхгүй байна. тооллогын үр дүн бөгөөд Улсын хэмжээнд

ХҮСНЭГТ 1.3 ТООН СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ТҮҮВЭРЛЭЛТ, ХЭМЖЭЭ

№	Албан бус сектор	Нийт	Судалгаанд хамрагдах тоо
1	ТҮЦ	989	1140 албан бус сектор судалгаанд хамрагдана.
2	Гутал, хувцас засвар	475	
3	Авто засвар	400	
4	Дугуй засвар	256	
5	Авто машин угаалга	191	
6	Жижиглэн худалдааны цэг	9134	
7	Хүнсний чингэлэг	121	
8	Хүнсний бус чингэлэг	413	
9	Лангуу	7036	
10	Дэлгүүр	1569	
Нийт		11445	

ХОЁР. СУДАЛГААНЫ БАРИМТ БИЧГИЙН СУДАЛГАА

2.1 Монгол Улсын Засгийн газраас Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх үүднээс нийгэм, эдийн засгийн хүрээнд хэрэгжүүлж буй бодлого, шийдвэр

Хууль. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 4 сарын 29-ний өдөр “Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай” хуулийн төслийг баталсан байна.

Уг хуулийн зорилт нь коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал (цаашид “цар тахал” гэх)-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Цар тахлаас урьдчилсан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. Уг хуулийг зүйл тус бүрээр авч үзвэл:

- Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах хууль тогтоомж
- Хуулийн үйлчлэх хүрээ

- Хуулийн нэр томъёоны тодорхойлолт
- Үйл ажиллагаанд баримтлах зарчим
- Монгол Улсын Их Хурлаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Засгийн газраас авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Улсын онцгой комиссоос авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Төрийн бусад байгууллагаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Төв банк болон арилцааны банкнаас авч хэрэгжүүлэх арга хэмжээ
- Эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, арга хэмжээнд тавих шаардлага
- Иргэний эрх, үүрэг
- Аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг
- Хэвлэл мэдээллийн байгууллагын үүрэг
- Хандив
- Эд хөрөнгийн дайчилгаа
- Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага
- Хуулийн үйлчлэх хугацаатай холбоотой эрх зүйн зохицуулалтын талаар түлхүү тусгасан байна.

Тогтоол.

Манай урд хөрш БНХАУ-д Шинэ төрлийн Коронавируст халдварын нөхцөл байдал хүндэрч, Монгол улсын Засгийн Газар шинэ төрлийн вирусын халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээний хүрээнд 02 дугаар 13-ны өдрөөс эхлэн “Гамшгаас хамгаалах Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт” шилжиж, Монгол Улс, БНХАУ хооронд агаар, төмөр замаар зорчих хөдөлгөөнийг зогсоосон юм. Монгол Улсын Засгийн газраас Шинэ Төрлийн Коронавируст цар тахлийн эдийн засагт учруулах хүндрэлийг даван туулах дараах дараах арга хэмжээнүүдийг танилцуулж байна.

ХҮСНЭГТ 2.1. КОРОНАВИРУС ЦАР ТАХЛААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ЗГ-ЫН ТОГТООЛ

№	Тогтоол	Батлагдсан он, Тогтоол
1	Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай	ЗГ-ын 2020 оны 4 сарын 15-ны 139-р тогтоол
2	Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай	ЗГ-ын 2020 оны 5 сарын 6-ны 168-р тогтоол
3	Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед эдийн засгийг идэвхжүүлэх, иргэдийн амьжиргааг дэмжих нийгмийн хамгааллын зарим арга хэмжээний тухай	ЗГ-ын 2020 оны 5 сарын 6-ны 167-р тогтоол

Тогтоол №1.

Монгол УИХ-ын 2020 оны 4 сарын 9-ны өдөр Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай дугаар 21 тогтоол батлагдсан байна. Уг тогтоолоор нийт 4 төрлийн багц асуудал буюу иргэдийн эрүүл мэнд; орлогыг хамгаалах; ажлын байрыг хадгалах; эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр багц арга хэмжээнүүдийг авахаар тусгасан байна.

НЭГ. Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

Хүний амь нас, эрүүл мэнд, нийтийн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлж, үүнд шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвт зохицуулалт хийх, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн нэмэлт эх үүсвэр бүрдүүлэх замаар санхүүжүүлэх Коронавируст халдварын цар тахлын оношилгоо, эмчилгээнд хэрэглэх оношлуур, эм, эмнэлгийн

хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн бодис, амны хаалтыг импортоор оруулахад гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх

ХОЁР. Иргэдийн орлогыг хамгаалах чиглэлээр:

Монгол Улсын иргэний 2020 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдох хувь хүний орлогын албан татварыг чөлөөлөх бөгөөд үүнд дараах орлогод ногдох хувь хүний орлогын албан татвар хамаарахгүй. Үүнд:

а. Төрийн албан хаагчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого,

б. Төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн

өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого,

в. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжийн эх үүсвэрээр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын ажлыг хийж гүйцэтгэх тендерт шалгарч, тус ажлыг хийж гүйцэтгэж байгаа хуулийн этгээдэд ажилладаг хувь хүний зөвхөн уг ажилтай нь холбоотой олсон цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого.

Коронавируст халдварт цар тахлын улмаас өөрөөс үл хамаарах шалтгаанаар, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр үйл ажиллагаа нь зогссон болон 2020 оны 2,3 дугаар сарын үйл ажиллагааны борлуулалтын орлого нь өмнөх оны мөн үеэс 50 ба түүнээс дээш хувиар буурсан боловч ажлын байрыг хадгалж байгаа төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгжийн даатгуулагч Монгол Улсын иргэнд 2020 оны 4 сарын 1-ний өдрөөс 2020 оны 7 сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд ажилгүйдлийн даатгалын сангаас сар бүр 200.000 мянган төгрөгийн дэмжлэг олгох,

Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан сайн дураар даатгуулсан, нийгмийн даатгалын байгууллагатай мөн хуулийн 5 дугаар зүйлд заасан сайн дураар даатгуулахаар гэрээ байгуулсан Монгол Улсын иргэний 2020 оны 4 сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх

хугацаанд түүний хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцүү орлогод ногдох тэтгэвэр, тэтгэмж, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлж, даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцох

ГУРАВ. Ажлын байрыг хадгалах чиглэлээр:

Коронавируст халдварт цар тахлын улмаас үйл ажиллагаа нь доголдож, орлого нь буурч байгаа боловч ажлын байрыг хадгалж, хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан ирүүлсэн дараах хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагчийн 2020 оны 4 сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэлх хугацаанд төлөх тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл болон үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийг чөлөөлөх ба даатгуулагчийг мөн хугацаанд шимтгэл төлснөөр тооцно.

а. Төрийн байгууллагад ажиллаж байгаа даатгуулагч,

б. Төрийн өмчийн их, дээд сургуулиас бусад төрийн болон орон нутгийн өмчит, оролцоотой хуулийн этгээдэд ажиллаж байгаа даатгуулагч,

в. Гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар бараа, ажил, үйлчилгээ гүйцэтгэсний төлбөрөөс цалин авч нийгмийн даатгалын шимтгэл нь төлөгдөх даатгуулагч.

Ажахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 18.2, 18.3, 18.4, 18.5-д заасан албан татвар ногдох орлогын нийт дүн нь өмнөх татварын жилд 1.5 тэрбум

төгрөгөөс бага байсан төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан албан татвар төлөгчийн 2020 оны 4 сарын 1-ний өдрөөс 2020 оны 10 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд олсон орлогод мөн хуулийн 20.1, 20.2.7-д заасны дагуу ногдуулсан тайлагнасан аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг чөлөөлөх;

2020 оны 2 сарын 1-ний өдрөөс 2020 оны 4 сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд ногдуулж тайлагнасан боловч хуульд заасан хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөөгүй төрийн болон орон нутгийн өмчит, түүний оролцоотой хуулийн этгээдээс бусад аж ахуйн нэгж, байгууллагыг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан торгох шийтгэл, мөн зүйлийн тайлбарын хоёр дахь өгүүлбэрт заасан алдангиас тус тус чөлөөлөх,

2020 оны 2 сарын 1-ний өдрөөс 2020 оны 9 сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд татвар төлөгчийн хуулийн дагуу ногдуулсан тайлагнасан төлбөл зохих татварыг хуульд заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд уг хугацаанд ногдуулах татварын алданги, торгуулиас тухайн татвар төлөгчийг нэг удаа чөлөөлөх,

2020 оны 2 сарын 1-ний өдрөөс 2020 оны 9 сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ, хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь гэрээ болон Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан төлбөрийн

баримтаар нотлогдсон тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх,

2020 оны 3 сарын 1-ний өдрөөс 2020 оны 6 сарын 30-ны өдрийн хооронд элсэн чихэр, ургамлын тос, бүх төрлийн хүнсний будаа, 15000 мянган тонн элит үрийн улаан буудай, 160.000 мянган тонн хүнсний улаан буудайг импортлоход гаалийн болон импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх,

ДӨРӨВ. Эдийн засгийг идэвхжүүлэх чиглэлээр:

Ариутгал, халдваргүйжүүлэлт, эрүүл ахуйн горимд иргэдийг эрүүл, аюулгүй орчинд үйлчлүүлэх нөхцөл бүрдүүлсэн үйлдвэр, үйлчилгээний газруудыг үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэх боломжоор хангаж ажиллах,

Эдийн засгийг төрөлжүүлэх, дэмжих, ажлын байр бий болгох, нийгмийн халамжийн үйлчилгээг сайжруулах зорилгоор гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл арга хэмжээ идэвхжүүлэх, үр ашгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах, эх үүсвэр бүрдүүлэх гэрээ, хэлэлцээрийг байгуулах, түүнийг УИХ-ын чуулганаар нэн яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх,

Дотоодын аж ахуйн нэгжийг дэмжих зорилгоор төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, үйлчилгээний сонгон шалгаруулалтыг хийхдээ нэн тэргүүнд үндэсний үйлдвэрлэгчийг шалгаруулж байх зарчим баримтлах,

Дэлхийн улс орнуудад хэрэгжүүлж байгаа сайн туршлагыг нэвтрүүлж төр, хувийн хэвшлийн ажилтан, албан хаагчийг цахимаар ажиллах нөхцөлийг хангах, боловсролын алсын сайн сургалтын үйлчилгээг үзүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах хяналт бүхий цахим худалдааг дэмжих, импортын бүтээгдэхүүнийг орлох дотоодод үйлдвэрлэдэг хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хангамжийг сайжруулах зэрэг арга хэмжээнд шаардлагатай үнэ, тарифын хөнгөлөлтийг үзүүлэх, ЖДҮ-ийг хөгжүүлэх сангийн хөрөнгийг нэмэгдүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх,

Сахилга, дэг журам, хариуцлагын тогтолцоог дээшлүүлэх, эдийн засгийн сөрөг үйл дагавраас сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх ажлуудыг тусгасан байна.

Тогтоол №2.

Монгол УИХ-ын 2020 оны 4 сарын 29-ны өдрийн Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай дугаар 32 тогтоолыг баталсан байна. Уг тогтоолд:

- Эрүүл, найдвартай, ил тод, нээлттэй, олон нийтийн хяналттай, харилцагчид хүртээмжтэй банкны тогтолцоог хөгжүүлж, банкны салбарын реформ хийх;
- Банкны зээлийн хүүг болон зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах;
- Мөнгө хүүлэлтийг хязгаарлах замаар зээлдэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн

орчныг бүрдүүлэх;

- Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх;
- Төрийн үйлчилгээний болон төрийн тусгай албан хаагчдад зориулсан ипотекийн зээлийн шинэ бүтээгдэхүүн гаргах хүрээнд түрээслээд өмчлөх хэлбэртэй орон сууцны тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх, орон сууцны ипотекийн зээлийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх;
- Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх;
- Улсын ерөнхий прокурорын газар, Авлигатай тэмцэх газар, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, банкны эрх хүлээн авагч нартай хамтарсан ажлын хэсэг байгуулж, татан буугдсан банкны чанаргүй активыг шуурхай барагдуулах, төлбөрт хураагдсан үл хөдлөх эд хөрөнгө болон улсын орлогод хураагдсан эд хөрөнгөөс олсон орлогыг эдийн засгийн эргэлтэд оруулж, эмнэлэг, сургууль, улсын хэрэгцээнд ашиглах;
- Төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх;
- Иргэний тэтгэвэр барьцаалсан зээлийн төлбөрийг төрөөс нэг удаа төлөх арга хэмжээний хүрээнд банканд байршуулсан нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийг чөлөөлөх;
- Эдийн засгийг идэвхжүүлэх, хямралын эсрэг тусгай зорилтот сан байгуулах.
- Малчдын орлогыг нэмэгдүүлэх, ноолуурын салбарын дотоодын

үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор:

- а. ноолуурын түүхий эдийн нөөц бүрдүүлэх, ноолууран бүтээгдэхүүнийг экспортлохтой холбогдуулан ноолуурын үйлдвэрлэл эрхлэгчдэд хөнгөлөлттэй зээл олгох үйл ажиллагааг яаралтай зохион байгуулах;
- б. ноолуурын экспортыг дэмжих чиглэлээр ноолуурыг хилийн бүх боомтуудаар саадгүй нэвтрүүлэх, холбогдох хураамжуудын хэмжээг "0" болгох асуудлыг шийдвэрлэх;
- в. малчдын орлого болон үндэсний үйлдвэрүүдийг дэмжих зорилгоор ноолуурын зах зээлийн суурь үнэ дээр 1 кг тутамд 20 000 /хорин мянган/ төгрөгийн урамшууллыг Малын генетик нөөцийн тухай хуульд заасан малчин, мал бүхий этгээд бүрд олгох;
- г. ноолуурын зах зээлд өрсөлдөөнийг бий болгож, бодит үнэ тогтоох зорилгоор гадаад улсын худалдан авагч нарыг ноолуур бэлтгэх үйл ажиллагаанд татан оролцуулах ажлыг шуурхай зохион байгуулах.

Тогтоол №3.

ЗГ-ын 167-р тогтоолд Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалттай холбогдуулан эдийн засгийг сэргээх талаар дараах дөрвөн багц арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд:

- а. 0-18 насны хүүхэд бүрт 4 дүгээр сарын 1-нээс 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 70.000 төгрөгөөр нэмэгдүүлж 100.000 төгрөг болгон олгоно. Улсын хэмжээнд

1 сая 140 мянган хүүхэд хүүхдийн мөнгөн тэтгэмж авна.

- б. Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн иргэнд олгож байгаа хүнсний талоныг 5 сарын 1-ээс 10 сарын 1-ны өдөр хүртэл хоёр дахин нэмэгдүүлнэ. Ингэснээр 122.000 мянган насанд хүрэгч 32.000 төгрөг, 118.200 мянган хүүхэд тус бүр 16.000 төгрөгийн хүнсний талоны дэмжлэг авах юм.
- в. Нийгмийн халамжийн сангаас сар бүр дараах иргэдэд олгодог 188.000 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 5 сарын 1-ээс 10 сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд тус бүр 100.000 төгрөгөөр нэмэгдүүлж олгоно. Үүнд:
 - Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй ахмад настнууд
 - Тэжээгч болон асран хамгаалагчгүй хагас, бүтэн өнчин хүүхэд
 - Олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх
 - Одой хүмүүс
 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэд гээд нийт 62.600 мянган иргэн хамрагдана.

- г. Малчдын орлогыг нэмэгдүүлж, ноолуурын салбарын дотоодын үйлдвэрлэлийг дэмжих талаар УИХ-аас өгсөн чиглэлийн дагуу малчдад тушаасан ноолуурын нэг килограмм тутамд 20.000 төгрөгийн урамшуулал олгохоор шийдвэрлэсэн. Урамшууллыг 2019 оны жилийн эцсийн мал тооллогын А данс дахь ямааны тоог үндэслэн олгохоор болсон.

Бусад.

Монгол улс уг вирусын тархалтаас шалтгаалан ард иргэддээ зориулан авч буй арга хэмжээ:

- БНХАУ-д корона вирусын тархалт Улсын онцгой комисс 2020.01.24ны өдрийн I хурлаар Ерөнхий боловсролын сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр 2020 оны 1 дүгээр сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэл хаахыг, Тогтоосон хугацаанд суралцагчдад сургалтын хөтөлбөрийн дагуу мэдлэг олгох ажлыг цахим хэлбэрээр байгуулах арга хэмжээ авахыг, Олон нийтийг хамарсан төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулахыг түр хугацаагаар хязгаарлахыг, тус тус үүрэг болгосон. / www.nema.gov.mn /
- Улсын онцгой комиссын 2020.01.30ны өдрийн II хурлаар Уламжлалт сар шинийн баярыг зөвхөн гэр бүлийн хүрээнд тэмдэглэхийг уриалж, бүх шатны төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд, нутгийн зөвлөл, хамт олны зохион байгуулалттай золголт хийхгүй байх талаар холбогдох арга хэмжээ авахыг, Цагаан сарын хүчит бөхийн барилдаан, морин уралдааныг зохион байгуулахгүй байхыг, тус тус үүрэг болгосон.
- Улсын онцгой комиссын 2020.02.10ны өдрийн IV хурлаар Монгол, Хятадын хилийн авто замын боомтуудаар нүүрс тээвэрлэлтийг 2020 оны 3 дугаар сарын 2ны өдрийг хүртэл зогсоож, холбогдох арга хэмжээ авахыг, Улсын хилээр амны хаалт экспортлоог хориглож, мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллахыг, Улсын хилээр нэвтрүүлж байгаа ачаа, бараа, бүтээгдэхүүн, тээврийн хэрэгслийн гадаргууны ариутгал, халдваргүйжүүлэлтийг стандартын дагуу хийж гүйцэтгэхийг тус тус үүрэг болгосон.
- Ковид 19 халдварын үеэр ажлын уян хатан нөхцөлөөр хангах. Албан байгууллагууд зайнаас буюу гэрээсээ ажиллах, цагийн хөлсийг хэвээр нь байлгаж бага цагаар ажиллуулах, 0-5 хшртэлх насны хүүхэдтэй ээжид 5 хүртэлх хоногийн цалинтай чөлөө олгох, 0-12 насны хүүхэдтэй эцэг эхийн ажиллах цагийг 1 цагаар багасгах. / www.unicef.org /
- Ковид 19 халдварын үеэр ажлын байранд авах арга хэмжээ: 00 өрөө цэвэрхэн байж, ажлын байран дээрх хүүхэд харах өрөө танхим цэвэр ус, саван, спиртийн суурьтай гар ариутгагчаар хангагдсан байх.
- Монгол Улсын Засгийн газрын 2020.03.18ны өдрийн ээлжит хуралдаанаар Зээлийн ангилал, эргэн төлөлтөд түр хугацаагаар өөрчлөлт орууллаа. Ипотек, цалин, тэтгэвэр болон бусад хэрэглээний зээл хэлбэрээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг Хэвийн зээлийн хувьд 15 хүртэлх хоног байсныг 90 хүртэлх хоног болгож, Анхаарал хандуулах” зээлийн хувьд 91-120 хүртэлх хоног, “Чанаргүй” зээлийн хувьд 121-ээс дээш хоног байхаар тус тус тогтоож мөрдөх; / www.zasag.mn /
- Засгийн газрын ээлжит бус хуралдаан 2020.03.27ны өдөр

1. 2020 оны 04.01-10.01 хүртэл зургаан сарын хугацаанд хувийн аж ахуйн нэгж, компаниуд болон хувиараа нийгмийн даатгалын шимтгэл төлдөг иргэдийг НДШ-ээс чөлөөлөх

2. 2020 оны 04.01-10.01 хүртэл зургаан сарын хугацаанд ажилтан, албан хаагчдын цалин, хөлст ХХОАТ ногдуулахгүй байх

3. 2020 оны 04.01-10.01 хүртэлх зургаан сарын хугацаанд албан татвар ногдох орлогын дүн нь өмнөх татварын жилд 1,5 тэрбум төгрөгөөс бага албан татвар төлөгчдийг ААН-ийн ОАТ-аас чөлөөлөх/ашигт малтмал, цацраг идэвхит ашигт малтмалын хайгуул хийх, олборлох, ашиглах, тээвэрлэх, борлуулах, согтууруулах ундаа, тамхины ургамал тарих, тамхи үйлдвэрлэх, импортлох, газрын тосны бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, бүх төрлийн шатахууныг импортлох, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэх, газрын тос хайх, олборлох, борлуулах үйл ажиллагаа хамаарахгүй/

4. COVID-19-ын тархалт, халдварын эрсдлээс сэргийлж, хорио цээрийн дэглэм хэрэгжүүлсэнтэй холбогдуулан үйл ажиллагаа нь доголдож орлого нь буурч байгаа боловч ажлын байраа хадгалсан хувийн хэвшлийн аж ахуй нэгжүүдийн ажилтан бүрт гурван сарын хугацаанд сар бүр 200.000 төгрөгийн бэлэн мөнгөний дэмжлэг олгох

5. Ноолуур бэлтгэлийн цаг болсонтой холбогдуулан, малчдын амжиргааг дэмжих зорилгоор ноолуур худалдан авагч, бэлтгэгчдэд гурван хувийн хүүтэй нэн хөнгөлөлттэй зээл олгох. Шаардагдах 300 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг шийдвэрлэх

6. Хүүхдийн мөнгийг гурван сарын хугацаанд 10.000 төгрөгөөр нэмэгдүүлж

олгох

7. 2020 оны 04.15-аас бензин, шатахууныг литр тутамд 300, түүнээс дээш төгрөгөөр бууруулах арга хэмжээг тус тус авч хэрэгжүүлнэ гэв. Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх энэхүү хариу арга хэмжээнд нийт 5,1 их наяд төгрөг шаардагдана хэмээн тооцоолжээ.

2.2 Монгол Улсын эдийн засаг:

Коронавирус халдварт цар тахлаас өмнөх ба одоо үеийн эдийн засгийн харьцуулалт

2019 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн талаарх мэдээлэл.


Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн нийт орлого нь 11.936.6 тэрбум төгрөг, дотоодын нийт бүтээгдэхүүн 5.4%-д хүрсэн байна. Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлт 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оноос 5.1%-иар өссөн байна. Импортоос хамаарах орлого 3.153.8 тэрбум төгрөг, иргэдийн хөдөлмөр эрхлэлтээс төвлөрүүлсэн орлого 2.862.5 тэрбум төгрөг, уул уурхайн салбарын орлого 3.138.9 тэрбум төгрөг, бусад салбараас 2.781.5 тэрбум төгрөгийн орлого олсон байна.

Эрэлт (ДНБ-ий өсөлт 2019 оны урьдчилсан гүйцэтгэлээр 4.9%) талаас эдийн засгийн өсөлтийн 8.3 нэгж хувийг эцсийн хэрэглээ (өрхийн болон ЗГ-ын хэрэглээ), 6.5 нэгж хувийг хөрөнгийн нийт хуримтлал, -9.9 нэгж хувийг цэвэр экспорт тус тус бүрдүүлжээ. Иргэд, хувийн байгууллагын зээл өссөн, өрхийн дундаж болон татварын орлого өссөн болон уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын хөрөнгө оруулалт нэмэгдсэнтэй (2019

онд Монгол Улсад орсон ГШХО-ын орох урсгал 6.3 хувиар өссөн) холбоотойгоор нийт хөрөнгө оруулалт 2019 онд бодит

дүнгээр өмнөх оноос 17.9%-иар өссөн нь эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлээ¹.

ГРАФИК 2.1 МОНГОЛ УЛСЫН ОРЛОГО, ЗАРЛАГА, ТЭНЦЭЛИЙГ СҮҮЛИЙН 5 ЖИЛИЙН БАЙДЛААР АВЧ ҮЗВЭЛ:



Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо

Дэлхийн банкнаас энэ 2 сард гаргасан Монгол Улсын эдийн засгийн тойм тайланд 2020-2021 онд хувийн хэрэглээний тогтвортой өсөлт, уул уурхай, аж үйлдвэрлэлийн салбарын хөрөнгө оруулалтын нөлөөгөөр эдийн засаг дунджаар 5.6%-иар өсөх төлөвтэй байна. Гэвч эдийн засгийн хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болохуйц гадаад болон дотоод хүчин зүйлсүүдийг анхааруулсан байна. Үүнд:

УИХ-ын ээлжит сонгууль болох гэж байгаагаар холбогдуулан ЗГ-аас хэрэгжүүлж буй эдийн засгийн хөтөлбөр тууштай хэрэгжихгүй тохиолдолд зах зээлийн

орчин, гадаад хөрөнгө оруулалтад сөргөөр нөлөөлнө гэж таамаглал дэвшүүлсэн. Засгийн эрх барьж байсан Монгол Ардын Нам үнэмлэхүй ялалт байгуулсан нь эдийн засгийн бодлого, хөтөлбөрт өөрчлөлт орох магадлал багасч байна.

Коронавирус нь БНХАУ-ын эдийн засагт үзүүлэх нөлөө нь Монголын эдийн засагт сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй хэмээн Дэлхийн банкнаас танилцуулсан.


2020 оны 5 сарын байдлаар Монгол Улсын нэгдсэн төсвийн мэдээлэл. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны нийт орлогыг 12.9 их наяд төгрөг байхаар

¹ Монгол банк. 2019 оны тайлан

баталсан. Үүнээс уул уурхайн салбараас 3.194.5 тэрбум төгрөг, импортоос 3.496.3 тэрбум төгрөг, бусад хүчин зүйлээс 5.067.5 тэрбум төгрөг, татварын бус орлогоос 1.141.7 тэрбум төгрөгийг бүрдүүлэхээр тооцсон байна. Төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 11.797.8 тэрбум төгрөг, ирээдүйн өв санд 977.0 тэрбум төгрөг, тогтворжуулалтын санд 125.2 тэрбум төгрөгийг төвлөрүүлэхээр тусгасан байна².

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2020 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээ 3.3 тэрбум төгрөг, нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн нийт хэмжээ 4.9 тэрбум төгрөг болж, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 1.6 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

ГРАФИК 2.2 МОНГОЛ УЛСЫН НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГО



Улсын нэгдсэн төсвийн орлогын 85.7%-ийг татварын орлого бүрдүүлж байна. Татварын нийт орлого 2020 оны эхний 5 сард 3.1 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 533.3 (14.9%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

НӨАТ-ын орлогын 96.7%-ийг ААНБ-ын татвар, 3.3%-ийг иргэдийн төлсөн татвар бүрдүүлсэн байна. НӨАТ-ын тайланг 2019 онд нийт 32.1 мянган ААНБ тушаасан. Тэдгээрийн 45% нь худалдааны салбарт

үйл ажиллагаа эрхэлдэг байна. НӨАТ-ын орлого 2020 оны эхний 2 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 70.3 (25.8%) тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. НӨАТ-ын орлого багассан нь НӨАТ төлөгч ААНБ-ын орлого буурснаас шалтгаалжээ. Мөн коронавирус цар тахал гарсантай холбогдуулан хөл хорио тогтоосноор Цагаан сарын баярыг энэ жил улс орон даяар тэмдэглэхийг хориглосон нь худалдаа, үйлчилгээ эрхлэгчдийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн нь харагдаж байна.

² https://mof.gov.mn/files/uploads/article/_%D1%82%D3%A9%D1%81%D3%A9%D0%B2_2020-pdf1.pdf

Үйлдвэрлэл эрхэлдэг ААНБ-ын борлуулалт 2020 оны эхний 5 сарын урьдчилсан гүйцэтгэлээр 1.2 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 230.3 (16.1%) тэрбум төгрөгөөр буурсан ба төмрийн үйлдвэрлэл, тамхи, химийн бүтээгдэхүүн, резин болон хуванцар бүтээгдэхүүн, хувцас, тавилга, нэхмэлийн үйлдвэрлэл 2.9-52.5%-иар буурсан.

Хүнс, хүнсний бүтээгдэхүүн, ундааны үйлдвэрлэл 2020 оны эхний 5 сард 620.4 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 469.6 (0.1%) тэрбум төгрөгөөр буурсан гэж ҮСХ-ноос мэдээллэсэн байна³.

ААНБ, иргэдэд олгосон нийт зээлийн хувьд хугацаа хэтэрсэн өрийн

үлдэгдэл 2020 оны 5 сарын байдлаар 17.2 их наяд төгрөг болж, өмнөх сараас 16.6 (0.1%) тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Гадаад худалдаа

2020 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 28%-иар буюу 1.580 сая ам. доллараар буурч 3.999 сая ам.доллар болсон байна. Үүнд экспорт 39%-иар буюу 1.257 сая ам.доллараар, импорт 14%-иар буюу 323 сая ам.доллараар тус тус буурсан нь нөлөөлөв. Тайлант хугацаанд худалдааны тэнцэл өнгөрсөн оны мөн үеэс 934 сая ам.доллараар буурч 14 сая ам.долларын ашигтай байна.

ХҮСНЭГТ 2.2. ГАДААД ХУДАЛДААНЫ ГҮЙЦЭТГЭЛ (САЯ АМ.ДОЛЛАР)

	Жилээр			Өөрчлөлт				Эхний 5 сар			Өөрчлөлт			
	2017	2018	2019	2018/2017		2019/2018		2018	2019	2020	2019/2018		2020/2019	
				Дүн	Хувь	Дүн	Хувь				Дүн	Хувь	Дүн	Хувь
Эргэлт	10.536	12.887	13.747	2.351	22%	860	7%	5.064	5.578	3.999	514	10%	(1580)	-28%
Экспорт	6.201	7.012	7.620	811	13%	608	9%	2.885	3.263	2.006	378	13%	(1237)	-39%
Импорт	4.335	5.875	6.127	1.540	36%	252	4%	2.179	2.315	1.992	136	6%	(323)	-14%
Тэнцэл	1.865	1.137	1.492	(728)		356	31%	706	948	14	242	34%	(934)	-99%

Эх сурвалж: Монгол банк 2020 он 5 сар

³ ҮСХ. Коронавирус ба Эдийн засаг. УБ.2020.06

Хөрш орнуудтай хийсэн худалдааг авч үзвэл, нийт бараа эргэлтийн 58% буюу 2.327 сая ам.доллартай худалдааг БНХАУ-тай, 15% буюу 583 сая ам.долларын худалдааг ОХУ-тай хийжээ. ОХУ-тай хийсэн худалдаа өмнөх оны мөн үеэс 10%-иар, БНХАУ-тай хийсэн худалдаа 37%-иар буурсан байна.

ХҮСНЭГТ 2.3. ИМПОРТЫН ГҮЙЦЭТГЭЛ (САЯ АМ.ДОЛЛАР)

Төрөл	2018			2019			2020			Δ	(2019/2018)		Δ	(2020/2019)	
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн %	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Тоо/хэм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөл т	%²	Дүн	Өсөл т	%²	
Хэрэглээний бүтээгдэхүүн	375	591	27%	340	652	28%		573	29%	62	10%	3%	(79)	-12%	-3%
Түргэн	175	318	15%	163	326	14%	362	328	16%	8	2%	0%	2	1%	0%
эдэлгээтэй	1	221	10%	1	231	10%	172	229	11%	9	4%	0%	(2)	- 1%	0%
Хүнс	199	42	2%	176	40	2%	1	44	2%	(2)	-5%	0%	4	11%	0%
Эм, тариа	74	54	3%	139	55	2%	189	54	3%	0	1%	0%	(1)	- 1%	0%
Бусад түргэн	23	273	13%	29	327	14%	107	246	12%	54	20%	2%	(81)	- 25%	- 4%
эдэлгээтэй	22	29	1%	79	27	1%									
бараа	1	43	2%	1	42	2%	42	27	1%	(2)	- 7%	0%	0	1%	0%
Удаан	28	171	8%	29	223	10%	34	38	2%	(1)	- 2%	0%	(4)	- 9%	0%
эдэлгээтэй	678	31	1%	523	35	2%	1	147	7%	52	30%	2%	(76)	- 34%	- 3%
Гутал, хувцас, цүнх	10	896	41%	12	977	42%									
Гэр ахуйн	1	570	26%	1	671	29%	31	33	2%	4	15%	0%	(2)	- 5%	0%
цах.хэрэгсэл ба тавилга	10	193	9%	11	237	10%	576	822	41%	81	9%	4%	(154)	-16%	-7%
Авто машин, түүний	264	377	17%	345	434	19%	13	530	27%	101	18%	5%	(141)	- 21%	- 6%
сэлбэг хэрэгсэл	18	238	11%	10	238	10%									
Бусад удаан	578	88	4%	680	67	3%	4	168	8%	44	23%	2%	(69)	- 29%	- 3%
	232	303	14%	16	258	11%									
	81	62	3%	80	9	0%	9	363	18%	57	15%	3%	(72)	- 16%	- 3%
	26	49	2%	34	45	2%									

эдэлгээтэй бараа	10	1159	1%3%	10	1259	1%3%	421	222	11%	0	0%	0%	(16)	- 7%	- 1%
Хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн	337	0	0%	391	0	0%	14	70	4%	(20)	-23%	- 1%	3	5%	0%
Машин, механик тоног төхөөрөмж, эд анги	578	122	6%	680	133	6%	634	269	13 %	(45)	-15%	- 2%	11	4%	0%
Суудлаас бусад тээврийн хэрэгсэл, эд анги	322	386	18 %	406	426	18 %	109	27	1%	(53)	- 86%	- 2%	19	215%	1%
Машин, механик, тоног төхөөрөмж, эд анги	130	207	9%	191	253	11%	80	45	2%	(4)	- 7%	0%	0	0%	0%
Барилгын материал	125	88	4%	83	111	5%	29	11	1%	1	10%	0%	(1)	- 11%	0%
Хөрөнгө оруулалтын бусад бараа	11	90	4%	2	62	3%	1	59	3%	(1)	- 1%	0%	1	1%	0%
Аж үйлдвэрлэлийн орц		4	0%		2	0%	1	0	0%	0	58%	0%	0	5%	0%
Хүнсний орц							356	125	6%	11	9%	0%	(8)	- 6%	0%
Химийн бүтээгдэхүүн							634	326	16 %	40	10 %	2%	(99)	-23 %	-4%
Даавуу, утас, арьс, савхин							333	169	8%	46	22%	2%	(84)	- 33%	-4%
Эдлэл							183	87	4%	22	25%	1%	(23)	- 21%	-1%
Цахилгаан эрчим хүч							119	70	4%	(28)	- 31%	- 1%	8	13%	0%
							10 0	2	0%	(1)	-36 %	0%	(1)	-23 %	0%

Металлын хүдэр, баяжмал болон хаягдал Бусад аж үйлдвэрлэлийн зориулалтай Нефтийн бүтээгдэхүүн Дизель түлш АИ- 92, АИ- 95 А- 80 болон бусад Бусад															
Нийт дүн		2,179			2,315		1,992			136	6%		(323)	-14%	

Импортын өөрчлөлт 2020 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүний, импорт 154 сая ам.доллараар, нефтийн бүтээгдэхүүний импорт 99 сая ам.доллараар, хэрэглээний

бүтээгдэхүүний импорт 79 сая ам.доллараар буурсан бол аж үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний импорт 11 сая ам.доллараар өссөнөөр нийт импорт 323 сая ам.доллараар буурсан үзүүлэлтийг харуулж байна.

ХҮСНЭГТ 2.4. ЭКСПОРТЫН ГҮЙЦЭТГЭЛ (САЯ АМ.ДОЛЛАР)

Төрөл	2018			2019		2020		Δ (2019/2018)			Δ (2020/2019)				
	Тоо/хэм (мян нэгж)	Дүн %	Тоо/х эм (мян нэгж)	Дүн	%	Тоо/х эм (мян нэгж)	Дүн	%	Дүн	Өсөл т	% ²	Дүн	Өсөлт	% ²	
1. Уул уурхай		2,5 71	89%		2, 932	90%		1,881	94%	361	14 %	13%	(1,051)	- 36 %	-32%

1.1. Зэсийн хүдэр, баяжмал	601	823	29%	624	893	27%	556	614	31%	70	8%	2%	(279)	- 31%	- 9%
1.2. Чулуун нүүрс	14,114	1,104	38%	15,061	1,272	39%	6,291	513	26%	168	15%	6%	(759)	- 60%	-23%
1.3. Боловсруула агүй нефть	2,766	177	6%	2,628	150	5%	664	25	1%	(27)	-15%	-1%	(125)	- 84%	- 4%
1.4. Төмрийн хүдэр, баяжмал	2,768	131	5%	3,489	207	6%	3,449	235	12%	76	58%	3%	27	13%	1%
1.5. Мөнгөжөөгүй алт /кг/	3,432	144	5%	4,665	196	6%	4,918	266	13%	51	36%	2%	70	36%	2%
1.6. Цайрын хүдэр, баяжмал	52	93	3%	65	96	3%	58	71	4%	3	3%	0%	(25)	- 26%	- 1%
1.7. Жонш, лейцит, нефелинт	153	51	2%	221	75	2%	237	60	3%	24	48%	1%	(14)	- 19%	0%
1.8. Молибдений хүдэр, баяжмал	2	18	1%	2	20	1%	3	18	1%	2	11%	0%	(3)	- 13%	0%
1.9. Гянтболдын хүдэр, баяжмал	0	2	0%	0	2	0%	0	0	0%	0	1%	0%	(2)	- 98%	0%
1.10. Мөнгө /тонн/	0	0	0%	0	-	0%	79,390	49	2%	(0)		0%	49	0%	1%

1.11. Бусад	211	27	1%	75	21	1%	28	31	2%	(6)	- 23%	0%	10	47%	0%
2 . Мал аж, ахуй	209	19 1	7%	184	224	7%	13 2	62	3%	33	17 %	1%	(162)	- 7 2 %	- 5 %
2.1. Амьд мал, малын мах	9	20	1%	11	21	1%	1	2	0%	0	1%	0%	(19)	- 91%	- 1%
2.2. Арьс, шир	191	11	0%	161	8	0%	12 6	6	0%	(2)	- 23%	0%	(3)	- 32%	0%
2.3. Малыг өлөн гэдэс	0	3	0%	0	4	0%	0	4	0%	1	32%	0%	0	0%	0%
2.4. Ноолуур	5	151	5%	5	181	6%	3	47	2%	30	20%	1%	(134)	- 74%	- 4%
2.5. Ноос, бусад үс, хялгас	3	5	0%	5	9	0%	3	3	0%	4	79%	0%	(6)	- 63%	0%
2.6. Бусад	0	1	0%	2	1	0%	0	0	0%	(0)	- 20%	0%	(0)	- 64%	0%
3 . Газар тариалан	6	2	0%	22	5	0%	16	5	0%	4	205 %	0%	(0)	- 8 %	0%
4 . Аж үйлдвэрлэл	132	12 1	4%	195	10 2	3%	11 3	58	3%	(19)	- 16 %	- 1%	(44)	- 4 3 %	- 1%
4.1. Хүнс	10	30	1%	11	27	1%	2	6	0%	(3)	- 11%	0%	(21)	- 77%	- 1%
4.2. Ноолууран эдлэл	0	7	0%	0	11	0%	0	5	0%	4	60%	0%	(6)	- 56%	0%
4.3. Бусад хувцас, гутал, эдлэл	1	5	0%	1	4	0%	2	4	0%	(1)	- 11%	0%	(0)	- 3%	0%
4.4. Уул уурхай	15	46	2%	51	42	1%	9	29	1%	(3)	- 7%	0%	(13)	- 31%	0%


4.5. Цахилгаан, электрон бараа	0	0	0%	0	0	0%	0	0	0%	0	15%	0%	(0)	- 6%	0%
4.6. Машин механик, тоног төхөөрөмж, эд анги	1	31	1%	1	14	0%	1	12	1%	(17)	-54%	- 1%	(3)	- 18%	0%
4.7. Бусад	104	2	0%	131	3	0%	98	2	0%	1	33%	0%	(1)	-40%	0%
5 . Бусад	0	0	0%	0	0	0%	0	0	0%	(0)	- 6 %	0%	0	30%	0%
Нийт дүн		2,8 8 5			3,2 6 3		2, 0 0 6			378	13 %		(1,257)	-39 %	

2020 оны эхний 5 сард уул уурхайн бүтээгдэхүүний экспорт тоо хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 1.241 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалж 16 сая ам.доллараар буурсан байна. Үүнээс чулуун нүүрс, зэсийн баяжмалын экспортын биет хэмжээний өөрчлөлтөөс шалтгаалж 790 сая ам.доллараар, үнийн

өөрчлөлтөөс шалтгаалж 247 сая ам.доллараар тус тус буурсан байна. Мал аж ахуйн бүтээгдэхүүний экспортын бие хэмжээний бууралтаас шалтгаалж 81 сая ам.доллараар, үнийн өөрчлөлтөөс шалтгаалан 81 сая ам.доллараар буурсан байна⁴.

⁴ Монгол банк. Гадаад худалдааны тойм. 2020. 05 сар

ГРАФИК 2.3 2019 ОНЫ ЭКСПОРТ, ИМПОРТЫН БҮТЭЦ, УЛС ОРНООР ХАРУУЛБАЛ:



2020 оны эхний 5 сарын гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 14%-иар буюу 323 сая ам. доллараар буурсан байна.

Экспорт 2020 оны эхний 5 сарын гүйцэтгэл өнгөрсөн оны мөн үеэс 39%-иар буюу 1.257 сай ам.доллараар буурсан байна. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортийн бууралт нь нийт экспортыг 32 нэгж хувиар бууруулах шалтгаан болж байна.


ГУРАВ.СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН, АНХААРАХ АСУУДЛУУД

3.1 Бичил бизнес эрхлэгчид (Худалдааны салбарт)

Монгол Улсын хэмжээнд бөөний болон жижиглэн худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг нийт 79024 аж ахуй нэгж бүртгэлтэй байгаагаас 2020 оны 1 сарын 31-ний байдлаар 38649 нь үйл ажиллагаа явуулж байна.

Улаанбаатар хотын 9 дүүргийн хэмжээнд нийт худалдааны салбарт 10 төрлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж буй нийт 11445 албан бус сектор байна. Эдгээр секторүүдийг төрлөөр нь авч үзвэл:

ГРАФИК 3.1 СУДАЛГААНЫ ТҮҮВЭРТ ХАМРАГДСАН АЛБАН БУС СЕКТОРУУД, БҮЛГЭЭР, ТООГООР



3.2 Бичил Бизнес Эрхлэгчдийн Орчин нөхцөл, Үйл ажиллагааны чиглэл

төлөөллийг жигд хамруулах зорилго тавьсан.

Судалгааны мэдээлэл цуглуулах ажлыг 2020оны 7 дугаар сарын 7-оос 26-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Баянгол, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн нутагт байрлан үйл ажиллагаа явуулдаг хувиараа хөдөлмөр эрхлэгч 1145 иргэнийг хамруулан хийлээ. Мэдээлэл цуглуулахдаа Нийслэлийн Статистикийн газраас авсан мэдээлэлд тулгуурлан эх түүврийн бүтцийг хадгалах, хотын төвийн бүс болон захын хорооллуудад хөдөлмөрлөдөг иргэдийн


Албан бус сектор гэдэг нь ихэнхдээ бүртгэл, татвар, хуулийн зохицуулалтаас гадуур, далд эдийн засгийн чанартай, тогтворгүй шинжтэй байнгын бус үйл ажиллагаа явуулдаг, ажлын нөхцөл, нийгмийн хангамж муутай сектор юм. Энэхүү секторт ажиллагсдад шил түүгчдээс эхлээд лангуу түрээслэгчид, хувиараа ашигт малтмал олборлогчид гээд цаашилбал хэд хэдэн хүн хөлслөн ажиллуулдаг бизнес эрхлэгчид, жижиг үйлдвэрлэгчид гэхчлэн эрхэлж буй үйл ажиллагааны цар хүрээгээрээ ялгаатай

олон янзын бүлэг хүмүүс багтана.

Судалгааны мэдээллийг цуглуулах, боловсруулах ажлыг хийхэд Улаанбаатар хотын албан бус секторын нийгэм эдийн засгийн суурь үзүүлэлтүүд олдохгүй байсан нь зарим нэг өөрхшээлийг үүсгэж байна. Монгол Улсын Их Хурлын 2006 оны 01 дүгээр тогтоолоор “ТӨРӨӨС АЛБАН

БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ыг батлан гаргаж албан бус хөдөлмөр эрхлэлтийг үндэсний статистикийн бүртгэл, тооцооны системд хамруулж, мэдээлэл, судалгааг боловсронгуй болгох зорилтыг дэтшүүлсэн боловч бүртгэл хяналтын тогтолцоо өнөөг хүртэл тааруухан хэмжээнд байгааг хэлэх нь зүйтэй.

ГРАФИК 3.2 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭН ЯВУУЛЖ БУЙ ЧИГЛЭЛ



Судалгаанд хамрагдсан иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн бүтцээс харахад эх түүврийн бүтэц бүрэн хадгалагдсан бөгөөд

түүнийг төлөөлөх чадвартай хэмээн үзэж бүрэн болно.

ХҮСНЭГТ 3.1 АЛБАН БУС СЕКТОРТ АЖИЛЛАГСДЫН ХҮЙСИЙН ХАРЬЦАА

Албан бус сектор			Эр	Эм	Нийт
а2	1	ТҮЦ	21	68	89
		% within question 2	23.6%	76.4%	100.0%
	2	Гутал, хувцас засвар	21	36	57
		% within question 2	36.8%	63.2%	100.0%
	3	Авто засвар	36	9	45
		% within question 2	80.0%	20.0%	100.0%
	4	Дугуй засвар	17	7	24
		% within question 2	70.8%	29.2%	100.0%
	5	Автомашин угаалга	16	8	24
		% within question 2	66.7%	33.3%	100.0%


6	Жижиглэн худалдааны цэг	7	23	30
	% within question 2	23.3%	76.7%	100.0%
7	Хүнсний чингэлэг	43	125	168
	% within question 2	25.6%	74.4%	100.0%
8	Хүнсний бус чингэлэг	15	39	54
	% within question 2	27.8%	72.2%	100.0%
9	Лангуу	100	266	366
	% within question 2	27.3%	72.7%	100.0%
10	Дэлгүүр	39	121	160
	% within question 2	24.4%	75.6%	100.0%
11	Бусад	17	38	55
	% within question 2	30.9%	69.1%	100.0%

Албан бус секторт ажиллагсадын 30.9 хувь нь эрэгтэй, 69.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Гол төлөв автозасвар, дугуй засвар, автомашин угаалгын төвүүдэд эрчүүд гол төлөв ажилладаг бол бусад салбаруудад эмэгтэйчүүд дийлэнх хувийг эзэлж байна.

Ажиллах хүчин уламжлалт хөдөө аж ахуй салбараас аж үйлдвэр, үйлчилгээний салбарт шилжиж байгаа. Сүүлийн жилүүдэд огцом нэмэгдсэн ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийн өсөлт, эдийн засагт аж үйлдвэрийн салбарын эзлэх жин нэмэгдэхийн хэрээр энэ салбарт ажиллагч эрчүүдийн тоо нэмэгдсээр байна. Үүнийг дагалдан өсөх үйлчилгээний салбарт эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин нэмэгдсэн хэмээн судлаачид үздэг билээ. Хүүхэд харах, гэрийн ажил хийх,

суралцах, тэтгэвэрт эрт гарах зэрэг нь эмэгтэйчүүдийг ажлын цагт үл баригдах бизнес, хөдөлмөр эрхлэлтийн салбарыг сонгох шалтгаан болж байна. Зөвхөн уул уурхан салбарын өсөлтөөс хамааралтай эдийн засгийн үйлчилгээний салбарыг эрхлэх нь иргэдийг эдийн засгийн хараат болгох, бие даасан үйл ажиллагаа эрхлэх чадамжыг нь улам бүр боогдуулсаар байна. Нөгөө талаар дээр дурдсанаас бусад салбарын эзлэх хувийн жин туйлын бага мөртлөө орчин үеийн дэвшилтэт технологийг ашигласан, ирээдүйд ашиг орлого нь нэмэгдэх бололцоотой салбарын төлөөлөл огт байгаагүйг хэлэх нь зүйтэй. Бусад салбар гэдэгт барилга засвар, ачаа тээвэр, хүүхэд асрах гэх мэт ажлууд багтаж байгаа юм.

ГРАФИК 3.3 ҮЙЛ АЖИЛЛАГААГАА ЭРХЭЛЖ БАЙГАА ХУГАЦАА.



Үйл ажиллагаа эрхэлж байгаа хугацааг хөдөлмөр эрхлэлтийн салбараар харьцуулалт хийж үзвэл автотасвар, гутал хувцас засвар, үсчин зэрэг тодорхой мэргэжил, мэргэшил шаардсан салбарт ажиллагсад мөн хэрэглэгчдэд танигдан, тэдний итгэл дээр суурилсан бизнес эрхлэгчид буюу цахилгаан бараа, бэлэн хувцасны гэх мэт бизнес (Өөрөөр хэлбэл зах зээлийн зарчмаар тэдний лангуу тийм бараа зардаг, чанартай хэмээн хэрэглэгчдэд үнэлэгдэх, өөрийн гэсэн хэрэглэгчидтэй болох зорилготой) эрхлэгчид харьцангуй тогтвортойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Харин

чанар стандартын хувьд хоорондоо онц их ялгахаргүй жижглэн худалдаа, хүнсний лангуу, ТҮЦ эрхлэгчдийн ихэнхи нь 1-3 жил үйл ажиллагаагаа явуулдаг ажээ. Үүнээс гадна эрчүүд харьцангуй тогтвортой буюу шкал бүрт ижил тархсан үзүүлэлттэй байгаа бол эхний 3 жилдээ ажиллаж байгаа эмэгтэйчүүдийн хувь харьцангуй өндөр боловч 6-9 жил ажиллаж байгаа эмэгтэйчүүд огцом цөөрөх хандлагатай байна. Үүнийг ерөнхий хандлагаар нь авч үзвэл эмэгтэйчүүдийн амьдралд 3-9 жилийн хугацаанд ямар нэгэн өөрчлөлт гарах магадлал өндөр байдаг хэмээн үзэж болох юм.

ГРАФИК 3.4 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭН ЯВУУЛЖ БУЙ ГАЗАР ОРЧНЫ ШААРДЛАГА, СТАНДАРТЫГ ХАНГАСАН БАЙДАЛ.



Ерөнхийдөө тухайн салбартаа удаан хугацаагаар ажиллах тусам иргэд өөрийн ажлын байрны чанар, стандартад сэтгэл ханамжгүй байдаг байна. Тухайлбал ажлын байрны стандарт бүрэн хангагдсан хэмээн хариулсан хүмүүсийн 33 хувийг 1-3 жил ажиллаж байгаа иргэд бүрдүүлж байгаа бол 10-аас дээш жил тухайн салбарт ажиллаж байгаа иргэд 19 хувь байна. Энэ нь албан бус секторт олон жилийн хугацаанд хөдөлмөр эрхэллээ ч өөрийн ажлын байраа шинэчлэн сайжруулах бололцоо бага гардаг юм байна хэмээн ойлгож болох юм.

2011 онд “Шинэ толь” сэтгүүлээс гаргасан судалгаар ажлын байрны нөхцөл буюу хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн нөхцөл хангагдсан эсэх талаар асуусан асуултанд нийт оролцогчдын 38% нь хангагдсан (үүнээс өндөр хувьтай хариулсан нь хүнсний үйлдвэрлэл 88%, нийтийн хоол 64%, бусад салбарт ажиллагсад 55%); 42% нь хангагдаагүй (үүнээс өндөр хувьтай ХАА, газар тариалан 60%, жижиглэн худалдаа 51%, үйлчилгээ, засварын салбарт ажиллагсдын 42%) гэж хариулжээ. Дийлэнх хэсэг нь буюу 62% нь ажлын байрны нөхцөл хангагдаагүй хэмээн тус тус хариулж байжээ. Энэхүү

судалгаанд орон нутаг, тэр дундаа бичил уурхайд ажилладаг зарим нэг хүнийг хамруулсан байдаг хэдий ч ерөнхийдөө өнөөгийн байдлаар хөдөлмөрийн нөхцөл харьцангуй сайжирч байна гэж үзэх бүрэн боломжтой юм. Учир нь хөдөлмөрийн нөхцөл харьцангуй хүнд байж мэдэх авто засвар, угаалга зэрэг газруудад ажиллагсад хөдөлмөрийн нөхцөлдөө хангалуун байх нь их байгаа юм.

Нөгөө талаар эрчүүд (62.8 хувь) ажлын байрны нөхцөл, стандартад сэтгэл хангалуун байх нь эмэгтэйчүүдээс (43.5 хувь) нэлээд дээгүүр үзүүлэлттэй гарч байна. Гэтэл эрэгтэйчүүд гол төлөв авто

засвар, дугуй засвар, авто угаалга зэрэг хүнд нөхцөл бүхий ажлын байранд ажилладагийг харгалзан үзвэл энд эрэгтэй эмэгтэй хүмүүсийн сэтгэлзүйн төрөлхийн онцлог ялгааг харж болно. Харин хөдөлмөрийн нөхцөл хангагдахгүй байгаа шалтгаануудад ажлын байрны агааржуулалт муу хэмээн давхардсан тоогоор 29.4 хувь нь үзсэн байгаа юм. Ихэнхи худалдаа үйлчилгээний газруудад стандарт шаардлагын дагуу агааржуулалтын системийг суурилуулсан байх авч магадгүй КОВИД-19-ийн үеийн байдлаас хамааран агааржуулалтын асуудалд илүү их санаа зовнисон байх магадлал бий.

АСУУЛТ №1: ОРЧНЫ ШААРДЛАГА, СТАНДАРТ БҮРЭН ХАНГАГДААГҮЙ БОЛ ЯМАР АСУУДЛУУД ГАРДАГ ВЭ?

1. Зөвшөөрөлгүй ТҮЦ их байна	- 0.5
2. Машины зогсоол, талбайн асуудлыг шийдэх	- 8.6
3. Засвар үйлчилгээ хийх, орчны тохижилтод анхаарах	- 11.2
4. Замын ус	- 2.3
5. Тоос, шороо их	- 2.3
6. Замын гэрэлтүүлэг	- 1.3
7. Өвөл халаалт муу	- 8.1
8. Нарануул захыг байранд оруулах	- 1.6
9. Явган хүний зам	- 0.5
10. Ус зайлуулах хоолой байхгүй	- 1.8
11. Ариун цэврийн өрөө	- 2.3
12. Ус их нэвтэрдэг	- 6.5
13. Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл	- 0.3
14. Түрээсийн төлбөр өндөр	- 0.8
15. Стандартын бус барилга (цонх байхгүй)	- 1.8
16. Цэвэрлэгээ	- 2.3
17. Цахилгаан байнга тасардаг	- 4.7
18. Торгууль, татварын асуудал	- 1.0
19. Аюулгүй байдлыг хангаагүй	- 2.1
20. Мэргэжлийн хяналт хүнд сурталтай	- 0.8
21. Мэрэгч амьтад	- 0.3
22. Хүнсний бохирдол	- 0.5

23. Хулгай их гардаг	- 0.3
24. Хогны асуудал	- 3.9
25. Гадаа ажилладаг хүмүүсийн эрүүл мэнд	- 0.3
26. Эрүүл ахуйн орчин	- 2.6
27. Дуу чимээ ихтэй	- 2.1
28. Агааржуулалт муу	- 29.4

ГРАФИК 3.5 ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ГАЗРЫН ЭЗЭМШЛИЙН ХЭЛБЭР?






ГРАФИК 3.6 ТҮРЭЭСИЙН ТӨЛБӨРИЙН ХЭМЖЭЭ ХЭД ВЭ?



Хувиараа хөдөлмөр эрхлэгсэдийн 46.9 хувь нь 500 мянгаас доош түрээстэй, 42.6 хувь нь 500 мянгаас 2 сая төгрөгийн ажлын байрны түрээс түрээс төлж байна.

ГРАФИК 3.7 КОРОНАВИРУС ГАРСНААС ХОЙШ ТҮРЭЭСИЙН ЗАРДЛЫГ ЯМАР НЭГЭН БАЙДЛААР БУУРСАН ЭСЭХ.



АСУУЛТ №3: БУУРУУЛСАН ДҮНГ ҮНЭЭР БОЛОН ХУВИАР ҮНЭЛБЭЛ?

1. Буурсан	- 1.8
2. 900.000-1.000.000₮	- 3.3
3. 90%	- 0.5
4. 700.000-800.000₮	- 1.5
5. 80%	- 0.3
6. 70%	- 0.5
7. 60%	- 8.7
8. 500.000-600.000₮	- 2.8
9. 50.000₮	- 2.0
10. 50%	- 8.4
11. 40%	- 2.0
12. 300.000-400.000₮	- 2.5
13. 3%	- 0.5
14. 30%	- 10.7
15. 25%	- 4.3
16. 20%	- 29.3
17. 100.000-200.000₮	- 5.3
18. 15%	- 2.8
19. 10%	- 12.7

Засгийн газраас ажлын байрыг хадгалах зорилгоор 2020 оны 2 сарын 1-ний өдрөөс 2020 оны 9 сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд зах, худалдааны төв болон худалдаа, үйлдвэр, үйлчилгээ,

хувийн сургууль, цэцэрлэг, хүүхэд харах үйлчилгээний зориулалтаар байр, талбай түрээслүүлсэн албан татвар төлөгч түрээсийн төлбөрөө бууруулсан нь гэрээ болон Татварын ерөнхий хуулийн

28.5-д заасан төлбөрийн баримтаар нотлогдсон тохиолдолд бууруулсан хэмжээгээр түрээсийн орлогод ногдуулах аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлүүлэх шийдвэр гаргасан нь түрээсийн төлбөр буурсан байх магадлалтай байна. Үүнээс гадна ашиг орлого нь буурсан маш олон тооны

хувиараа хөдөлмөр эрхлэгсэд ажлын байраа сольж байгаа тул түрээслэгчид түрээсийн зардлаа бууруулах, тохижилт засвар үйлчилгээндээ анхаарах болжээ.

3.3 Бичил Бизнес Эрхлэгчдийн Орлого, Нийгмийн үйлчилгээ, Зээл тусламж

АСУУЛТ №4 БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧДИЙН САРЫН ОРЛОГЫН ҮНИЙН ДҮН ХЭД ВЭ?

1. Орлого тогтмол биш	- 0.5
2. 900.000-1.000.000	- 21.1
3. 500.000-900.000	- 16.5
4. 1.000.001-3.000.000	- 39.5
5. 3.000.001-5.000.000	- 9.5
6. 5.000.001-ээс дээш	- 6.6
7. 300.000-500.001	- 4.4
8. 100.001-300.001	- 1.1
9. 100.000 хүртэлх	- 0.9

АСУУЛТ №5 КОРОНАВИРУС ГАРАХААС ӨМНӨ БА ДАРАА САРЫН ОРЛОГОД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

Коронавирус гарахаас өмнө:

1. Хэвийн ажиллаж байсан	- 2.0
2. 900.000-1.000.000	- 15.3
3. 500.000-900.000	- 11.1
4. 1.000.001-3.000.000	- 43.5
5. 3.000.001-5.000.000	- 10.3
6. 5.000.001-ээс дээш	- 13.9
7. 300.000-500.001	- 2.4
8. 100.001-300.001	- 1.0
9. 100.000 хүртэлх	- 0.4

Коронавирус гарсны дараа:

1. Орлого эрс муудсан	- 24.3
2. Хэвийн ажиллаж байсан	- 2.7
3. 900.000-1.000.000	- 12.1
4. 500.000-900.000	- 15.6

5.	1.000.001-3.000.000	- 18.3
6.	3.000.001-5.000.000	- 3.3
7.	5.000.001-ээс дээш	- 3.2
8.	300.000-500.001	- 5.8
9.	100.001-300.001	- 1.5
10.	100.000 хүртэлх	- 1.2
11.	40-50% буурсан	- 8.5
12.	30% буурсан	- 1.5
13.	15-20% буурсан	- 0.9
14.	10% буурсан	- 1.2

Цартахлын хөл хорио тогтоохоос өмнө 1-3 сая төгрөг хүртэлх орлоготой иргэд 43.5 хувь байсан бол хөл хорио тогтоосноос хойш тэдний хэмжээ эрс буурч 18.3 хувь болж 2.3 дахин, 3-5 саяын орлоготой иргэдийн тоо 10.3 хувиас 3.3 хувь буюу 3 дахин, 5 саяаас дээш орлоготой иргэд 13,9 хувь байсан нь 3.2 хувь хүртлээ буюу 4 дахин буурсан байна. Төрөөс жижиг

дунд бизнес эрхлэгчдийг дэмжиж байгаа ч хувиараа хөдөлмөр эрхэлдэг иргэдэд нөлөөлөх нөлөөлөл байхгүй байна. Худалдаа үйлчилгээний төвд лангуу, талбай түрээсэлдэг иргэдийн түрээсийн үнэ буурахгүй хэвээрээ байх, худалдан авагч багасаж, бараа бүтээгдэхүүндээ явж чадахгүй санхүүгийн хүнд нөхцөлд орж байгаа.

ГРАФИК 3.8 КОРОНАВИРУС ЦАР ТАХАЛ ГАРСНААС ХОЙШ ИРГЭДИЙН ХУДАЛДАН АВАХ ЧАДВАРТ ЯМАР НӨЛӨӨ ГАРСАН БЭ?



ГРАФИК 3.9 КОРОНАВИРУС ЦАР ТАХЛААС ҮҮДЭН МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨНДӨРЖҮҮЛСЭН БАЙДАЛД ШИЛЖСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН МОНГОЛ УЛС ӨӨРИЙН БҮХ ХИЛЭЭ ХААСАН. ҮҮНТЭЙ ХОЛБООТОЙ ТАНЫ ЭРХЭЛЖ БАЙГАА БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЯМАР ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ УЧИРЧ БАЙНА ВЭ?



Коронавирус гарахаас өмнө ба дараа нь таны сарын орлогод ямар өөрчлөлт гарсан бэ? Коронавирус гарахаас өмнө цалин тогтмол байсан мөн амьжиргааны түвшин гайгүй дундаж хэмжээнд байсан. Коронавирус гарсанаас хойш орлого эрс буурсан. Корона

гарахаас өмнө бол 5-сая төгрөгний орлоготой ажиллаж байсан, харин энэ коронавирус өвчин гарсны дараа орлого эрс буурч 3-сая болсон доо. Тэгэхдээ яахав гайгүй ээ. Болж л байна.

*Баянзүрх дүүрэг.
Авто засварчин*

ГРАФИК 3.10 ТА ӨӨРИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙХЭЭ НИЙЛҮҮЛТЭЭ ХААНААС ХИЙДЭГ ВЭ?



АСУУЛТ №6 БАРАА АВДАГ УЛС:

1. Япон	- 1.2	6. Турк	- 0.9
2. БНХАУ	- 79.6	7. Солонгос	- 4.6
3. Вьетнам	- 0.3	8. Малайз	- 0.3
4. АНУ	- 0.9	9. Герман	- 0.3
5. ОХУ	- 11.4	10. Энэтхэг	- 0.3

АСУУЛТ №7 ГАДААД УЛС ОРНООС БАРАА БҮТЭЭГДЭХҮҮН АВДАГ БОЛ ЯМАР ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ ТУЛГАРЧ БАЙНА ВЭ?

1. Зарим нэр төрлийн барааг хилээр нэвтрүүлэхгүй байна	- 1.0
2. Зарим нэр төрлийн барааны үнэ хэт өссөн	- 0.3
3. Бараа тасарсан	- 8.3
4. Бараа муудаж ирж байна	- 1.8
5. Валютын ханшны хэлбэлзэл	- 6.8
6. Захиалсан бараа дутуу, жин хэмжээндээ хүрэхгүй байгаа	- 12.8
7. Захиалгын барааны чанар муу, сонголт хийж чадахгүй байна	- 6.3
8. Хугацаа маш их алдаж ирдэг, тээвэрлэлт удаан	- 26.2
9. Үнийн өсөлт	- 11.3
10. Татварын үнэ нэмэгдсэн	- 3.5
11. Хилээ нээх	- 4.5
12. Хил хаасан	- 5.8
13. Гаалийн татвар өндөр	- 11.3

Бараа бүтээгдэхүүний нийлүүлэлт дээр хугацаа маш их алдаж ирдэг 26.2 хувь, захиалсан бараа дутуу жиндээ хүрдэггүй 12.8 хувь гэж хариулсан байгаа нь бага

хэмжээний эргэлтийн хөрөнгөөр жижиг бизнес эрхлэгчдэд хамгийн эрсдэлтэй үзүүлэлт болно.


ГРАФИК 3.11 КОРОНАВИРУС ГАРСНААС ХОЙШ БАРААНЫ ТӨРӨЛ, ЗҮЙЛД ӨӨРЧЛӨЛТ ОРСОН УУ?



Хөл хорио тогтоосноос хойш хэрэглэгчдэд үйлчилдэг зарим нэг төрлийн бараа тасарсан хэмээн 50.9 хувь нь, ихэнхи барааг оруулж ирж чадахаа больсон хэмээн 17.1 хувь нь хариулсан байгаа. Гэхдээ тасарсан бараа бүтээгдэхүүн нь гол төлөв бэлэн хувцас зэрэг өөрийн биеэр үзэж сонголт хийх шаардлагатай бараа бүтээгдэхүүн борлуулагчдад ихээхэн тохиолдож байгаа байдалтай

байна. Харин тодорхой стандарт, хэмжээ, үйлдвэрлэгч нь тодорхой интернет болон алсын зайнаас захиалга өгөх бололцоотой бараа бүтээгдэхүүн тасалдаагүй хэвийн нийлүүлэлттэй байгаа нь харагдлаа. Тухайлбал угаалга цэвэрлэгээний бодис, автомашины эд анги, тодорхой брендийн сав баглаа боодол бүхий хүнсний бүтээгдэхүүн, тамхи, бичгийн хэрэглэл гм.

ГРАФИК 3.12 НИЙГМИЙН ДААТГАЛ ТӨЛДӨГ ЭСЭХ.



Судалгаанд хамрагдагсадын 44.3 хувь нь НДШ төлдөггүй гэж хариулсан байгаа нь харьцангуй өндөр үзүүлэлт байхаар харагдаж байна. ҮСХ-ны таамаглал судалгаагаар МУ-ын хэмжээнд хөдөлмөрийн насны 360'000 орчим хүн


нийгмийн даатгалын шимтгэл бараг төлөхгүй, албан бус секторт ажилладаг гэсэн тооцоо байдаг. Гэтэл энэ нь нийт хөдөлмөр эрхэлж байгаа иргэдийн 28.7 хувь юм.

Ажиллагчдын 39.3 хувийг гэрээгээр ажиллагчид, 35,0 хувийг хувиараа хөдөлмөр эрхлэгчид, 24,8 хувийг өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчид эзэлж байна. Хоршооллын гишүүд болон ажил олгогчид дөнгөж 0.2- 0,6 хувийг эзэлж байна. Тухайн үед өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын ихэнх нь буюу 61.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Ажил олгогч арван хүний ес нь, хувиараа хөдөлмөр эрхлэгч таван хүний гурав нь эрэгтэйчүүд байхад өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээнд цалин хөлсгүй оролцогч таван хүний бараг дөрөв нь эмэгтэйчүүд байна.

ҮСХ-ны Ажиллах хүчний
судалгааны үндсэн тайлан 2018

ГРАФИК 3.13 ХҮН АМЫН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАР ТӨЛДӨГ ЭСЭХ.




Монгол Улсын Их хурлаас 2019 оны 03 дугаар сарын 22-ны өдөр шинэчлэн баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байгаа.

Шинэчлэн баталсан Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 4.1.3 дугаар зүйлд “бичил худалдаа, ажил, үйлчилгээ эрхлэгч” гэж ажлын байр, лангуу зэрэг тодорхой байршилд байрлахгүй худалдаа, үйлчилгээ, зорчигч болон ачаа тээврийн үйлчилгээ эрхлэгч хувь хүнийг

ойлгоно гэж заасан. “Бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг аймаг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал тогтооно” гэсэн хуулийн зохицуулалтыг хэрэгжүүлэхээр байгаа. Гэхдээ НИТХ-аас энэхүү татварын хувь хэмжээг заасан эрх зүйн зохицуулалт гараагүй, иргэдээс санал авах хэмжээнд явагдаж байна. Иймээс иргэд патентаар, жишгээр, хувь хүний орлогын албан татварын хуулийн дагуу ИОТТ хуудсаар (Иргэний орлогын татвар төлөх хуудсаар) тайлагнаж албан татвараа төлдөг байна.

ГРАФИК 3.14 БИЗНЕСИЙНХЭЭ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ЗАРЦУУЛАХ ГЭЖ ЗЭЭЛ АВСАН БАЙДАЛ




АСУУЛТ №8 ТА ЗЭЭЛТЭЙ БОЛ ХЭЗЭЭ АВСАН БЭ?

1. 2019 он	- 36.3	8. 2013 он	- 0.9
2. 2020 он	- 20.1	9. 2012 он	- 0.6
3. 2018 он	- 19.2	10. 2011 он	- 0.6
4. 2017 он	- 10.2	11. 2010 он	- 2.1
5. 2016 он	- 5.1	12. 2008 он	- 0.2
6. 2015 он	- 3.6	13. 2005 он	- 0.2
7. 2014 он	- 0.9	14. 2000 он	- 0.2

Нийт зээл авсан иргэдийн 36.3 хувь нь 2019 онд зээл авсан байдалтай харагдаж байна. Гэхдээ манай судалгааны мэдээллийг 7 сард авсан тул (2020 онд зээл авсан иргэд 20.1 хувь) энэ жил иргэдийн авах зээлийн хэмжээ оны сүүлээр нэлээд нэмэгдэх нь тодорхой юм. Учир нь хэрэглээний

зээлийн дийлэнхи нь намар хичээл, сургууль эхлэх цагт ногддог билээ. Хэрэв байдал энэ хэвээр үргэлжилбэл иргэдийн хэрэглээний зээл асар ихээр өсөх, орлого буурсан иргэд найдваргүй зээлдэгч болж хувирах магадлал өндөр байх юм.

ГРАФИК 3.15 ТА ХААНААС ЗЭЭЛ АВСАН БЭ?



Банкны нэр:

1. Ёсон сайхан	- 0.4
2. Голомт банк	- 12.5
3. Төрийн банк	- 8.9
4. Транскапитал	- 1.6
5. Худалдаа хөгжлийн банк	- 6.7
6. Сүлд шонхор	- 0.2
7. Сайн ломбард	- 0.2
8. Неткапитал	- 0.4
9. Нар сарны хүүхдүүд ББСБ	- 0.2

10. Миний босс	- 0.2
11. Хас банк	- 14.5
12. Хаан банк	- 52.6
13. Капитрон банк	- 0.9
14. Богд банк	- 0.4

Банкны салбарын нийт активаар ХААН банк зах зээлд эзлэх хувийн 28.8 хувийг эзэлж байгаа хэдий ч жижиг бизнес, албан бус секторт ажиллагсадын 52.6 хувь нь ХААН банкнаас зээл авдаг гэсэн дүн гарч байна. Ийм учир ХААН банкны үйл ажиллагааны мэдээлэлд дахин анализ хийж үзэх шаардлагатай хэмээн дүгнэлээ. Учир нь бүх банкны салбарт актив болон

пассив адилхан өсөлттэй харагдаж буй мэт боловч найдваргүй зээлдэгч олонтой болж байгаа ХААН банкны үйл ажиллагаанд илүү их хүндрэл үүсч магадгүй болжээ. Монголын хамгийн олон харилцагчидтай банк хүндрэх нь эдийн засагт бас нэгэн эрсдэлийг дагуулах аюултай юм(19-р асуултад хариулсан байдлыг дор үзнэ үү).

ГРАФИК 3.16 ТАНЫ БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮ, ЗЭЭЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТТЭЙ ХОЛБООТОЙ ЯМАР ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ БАЙНА ВЭ?



Өмнөх оны мөн үед Монгол Улсын хэмжээнд чанаргүй зээлийн эзлэх хувь 10.6 хувь, хугацаа хэтэрсэн зээл 4.8 хувь, банкны үзүүлэлтээр чанаргүй зээл 8.7 хувь, хугацаа хэтэрсэн зээл 4.9 хувь байжээ. /Монгол Банк. Мөнгө, санхүүгийн статистик Танилцуулга. 2019 оны 7 дугаар сар / Харин манай судалгаанд хамрагдсан иргэдийн хариултаас харахад өнөөгийн байдлаар хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 29.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээлтэй, 16.2 хувь нь чанаргүй зээлдэгч болжээ гэж үзэж болохоор байна. Энэ нь өмнөх оны улсын дунджаас хэд дахин давсан

үзүүлэлт болжээ. Үүнээс гадна зээлийн чадвар үлэмж хэмжээгээр буурсан хэсэг нь машин угаалга, бэлэн хувцасны лангуу, барилга засвар, хөлсний жолооч гэх мэт хувиараа үйлчилгээ эрхлэгчдийн дунд их байна. Харин гутал, хувцас засвар арай илүү сайн үзүүлэлттэй байгаагаас иргэд илүүдэл болон тансаг хэрэглээнээс татгалзаж хэмнэлтийн горимд шилжих хандлагатай болсны шинж тэмдэг болно. Албан бус секторт хөдөлмөр эрхлэгсдийн 69 хувь нь эмэгтэйчүүд байгаа хэдий ч зээлийн эргэн төлөлтөд тэд арай илүү хариуцлагатай ханддаг байна. Ялангуяа

машин угаалга, барилгын засвар чимэглэл зэрэгт ажиллагсад дийлэнхи нь эрэгтэйчүүд байгаа бөгөөд тэдний зээлийн эргэн төлөлт харьцангуй өндөр хувиар буурчээ. Энэхүү салбаруудад буюу өөрийн тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт бага шаарддаг, зөвхөн хөлс хүчээ үнэлэн амьдардаг иргэд найдваргүй

зээлдэгчдийн эгнээнд шилжих үзэгдэл их боллоо. Мөн зээл авсан иргэдийн хувь хэмжээ үйл ажиллагаа эрхэлсэн хугацаанаас үл хамаарах хандлагатай буюу 61-63 хувийн хооронд хэлбэлзэлтэй байна. Өөрөөр хэлбэл хэдэн ч жил үйл ажиллагаа эрхэлсэн байсан банкны зээлээс хамааралтай хэвээр үлддэг ажээ.

Засгийн газраас бичил бизнес эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжсэн ямар арга хэмжээг аваасай гэж хүсэж байна вэ?

Зээлийн хүү маш өндөр байна. Энэ нь бид бүхэнд хүндрэл учруулж байна. Үүн дээр төр засаг маань

анхаарч бизнес эрхлэгч бид бүхэнд дэмжлэг үзүүлээсэй гэж бодож байна даа. Зээлийн хүүг арай жаахан багасгамаар байна. Тэгэхгүй бол арай л дэндлээ.

*Сүхбаатар дүүрэг.
Автомашин угаагч*

Дэлхийн банкнаас орнуудын эдийн засгийн үр ашигтай байдлыг хэмжих зорилготой Бизнес эрхлэлтийн индекс (Doing business index)-ийг гаргадаг. Мөн дэлхийн банкны эдийн засагчдын хийсэн судалгаагаар Бизнес эрхлэлтийн индекс ба тухайн орны бүтээмж нь хоорондоо эерэг хамааралтай байдаг бөгөөд Бизнес эрхлэлтийн индекс өндөртэй орон нь илүү өндөр бүтээмжтэй байдаг байна. Өөрөөр хэлбэл бизнесийн тогтвортой, сайн орчин нь илүү өндөр бүтээмжийг бий болгодог байна. МҮХАҮТ-аас гаргасан “Бизнес итгэлийн индекс судалгаагаар “Зээлийн өндөр хүү, хугацаа” гэсэн асуудлыг сүүлийн гурван жил дараалан хамгийн тулгамдаж буй асуудлаар нэрлэсэн байдаг. Гэтэл угаас бизнесийн орчинд сөргөөр нөлөөлж байгаа банкны зээлийн хүү нь Ковид-19-ийн нөхцөлд жижиг бизнес эрхлэгчдэд улам их дарамт болж байна.


Монгол УИХ-ын 2020 оны 4 сарын 29-ны өдрийн Коронавируст халдвар (Ковид-19)-

ын цар тахлын үед санхүү, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн үйлчилгээнд цахим шилжилт хийх арга хэмжээний тухай дугаар 32 тогтоолоор банкны зээлийн хүүг болон зээлийн эх үүсвэрийн зардлыг бууруулах, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих зорилгоор зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх, банкнаас бусад санхүүгийн салбарыг хөгжүүлэх зорилт тавьсан байдаг. Үүний дагуу Монгол банкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн шийдвэрээр эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргасан. Энэ хүрээнд нийт 76 мянга орчим зээлдэгчийн 663 тэрбум төгрөгийн хэрэглээний зээлийн нөхцөлд өөрчлөлт орсон байна. Монгол банкнаас гаргасан энэ шийдвэрийн талаар иргэд ямар мэдээлэлтэй байгааг

судалгаагаар тогтоох боломжгүй байсан сунгуулах явдал ихээхэн түгээмэл болж ч иргэд зээлийн эргэн төлөлтийн хугацааг байгаа нь харагдлаа.

3.4 Засгийн Газрын Хэрэгжүүлж буй бодлого шийдвэр

ГРАФИК 3.17 МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС КОРОНАВИРУС ЦАР ТАХЛААС ШАЛТГААЛАН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ АРИЛГАХ, ДАВАН ТУУЛАХЫН ТУЛД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА АРГА ХЭМЖЭЭ ХЭР ҮР ДҮНТЭЙ БАЙНА ВЭ?



Монгол Улсын Засгийн газраас Коронавирус цар тахлаас шалтгаалан эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, даван туулахын тулд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хэр үр дүнтэй байна вэ?

Яахав тодорхой хэмжээний нөлөө үзүүлж байгаа гэж үзэж байна.

Учир нь хүүхдийн мөнгийг 100.000 төгрөг болгон нэмэгдүүлсэн нь сайшаалтай зүйл юм уу даа. Манайх гэхэд 3 хүүхэдтэй 3 хүүхдийн 300.000 төгрөг гэдэг чинь болоод л явчихаж байгаа юм л даа.

*Баянзүрх дүүрэг.
Авто засварчин*

Монгол Улсын Засгийн газраас КОВИД-19-ийн үеийн хүндрэл бэрхшээлийг даван туулахын тулд нийгэм рүү чиглэсэн зарим нэг арга хэмжээг авч байгаа хэдий ч эдийн засаг бүхэлдээ хүндрэлд орж байгаа нь жижиг бизнес, хувиараа

хөдөлмөр эрхлэгчдэд хүндрэлтэй тусч байна. Ялангуяа аялал жуулчлал, хоол үйлдвэрлэл, зочид буудал гэх салбарууд зогсонги байдалд орсон нь тэднийг дагаж амьдардаг жижиг ханган нийлүүлэгчид, хөлсний жолооч, үйлчилгээний бусад

салбарт ажиллагсадын амьдрал хүндэрлээ. Эдийн засгийн хүндрэлийн бас нэгэн шалтгаан нь төрийн худалдан авалт багасч, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалт огцом буурсан нь ажилгүйдэл, нэмэгдэх, иргэдийн орлого буурах, үйлчилгээ хангамжийн салбарууд дампуурах үндсэн шалтгаан болж байна. Тухайлбал зам, барилгын салбарт хөлсөөр ажилладаг ачаа тээвэр, засвар үйлчилгээ, хүнсний болон бусад үйлчилгээ бусад үйлчилгээ эрхлэгчид ажилгүй зогслоо.

“Эдийн засгийн өрлсөлдөх чадварын судалгааны төв”-өөс гаргасан судалгааны дүнгээр 2020 оны 1-р улирлын байдлаар

банкны салбарын хамдгаламжийн хэмжээ 10 хувиар, харилцах 6 хувиар өссөн сайн мэдээ байгаа ч энэ нь КОВИД-19-ийн хөл хорио цээрийн дэглэмээс үүдэлтэй иргэдийн илүүдэл хөрөнгө байх магадлалтай юм. Жишээлбэл бар цэнгээний газрууд, үзвэр үйлчилгээний цэгүүдийн үйл ажиллагаанд зарим нэг хязгаарлалтыг хийсэн, баяр наадмыг тэмдэглэх уламжлалт арга хэмжээнүүдэд өөрчлөлт оруулсан нь иргэдийн хэрэглээг хумих нөхцөлийг бүрдүүлж өгсөн. Чухам үүнээс улбаалан үйлчилгээний салбаруудад хүндрэл үүсэх нь гарцаагүй билээ.

ХҮСНЭГТ 3.2 ЗАСГИЙН ГАЗРААС ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ДАРААХ ҮЙЛ АЖИЛЛАГААНУУДААС ХАМГИЙН ОНОВЧТОЙ ГЭСЭН ШИЙДВЭРҮҮДИЙГ ДЭМЖИЖ БҮЙ БАЙДАЛ.

№	Засгийн газраас хэрэгжүүлж буй ажлууд	Тоо	Хувь
1	0-18 насны хүүхэд бүрт 4 сарын 1-ээс 10 сарын 1-ний өдөр хүртэл хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100.000 болгосон.	945	33.8%
2	Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн хүнсний талоныг хоёр дахин нэмэгдүүлсэн	184	6.6%
3	Нийгмийн халамжийн сангаас сар бүр дараах иргэдэд олгодог 188 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 5 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд тус бүр 100.000 төгрөгөөр нэмэгдүүлсэн	301	10.8%
4	Бүх Аж ахуй нэгжийг нийгмийн даатгалын 26 хувийн шийтгэлээс 6 сар чөлөөлсөн	345	12.3%
5	Иргэдийн цалин хөлснөөс 6 сар орлогын албан татвар авахааргүй болсон.	131	4.7%
6	1.5 тэрбумаас доош орлоготой Аж ахуй нэгжүүдээс 6 сар ААНОАТ авахгүй болсон	112	4.0%
7	Шатахууны үнийг литр тутамд 300-400 төгрөгөөр бууруулсан	477	17.1%
8	Ажлын байраа хадгалсан хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн ажилтан бүрт 3 сарын хугацаанд сар бүр 200.000 төгрөгийн дэмжлэг үзүүлнэ	59	2.1%
9	Ипотекийн зээлтэй иргэдийн зээлийн төлөлтийг хойшлуулсан	205	7.3%
10	Малчдын орлого болон ноолуурын салбарын дотоод үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ноолуурын кг тутамд 20,000 төгрөгийн урамшуулал олгох болсон.	36	1.3%

**АСУУЛТ №9 ЗАСГИЙН ГАЗРААС БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ДЭМЖИХЭД ЯМАР АЖИЛ, АРГА ХЭМЖЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛАХЫГ
ХҮСЧ БАЙГАА ТАЛААР.**

1. Зөв бодлого хэрэгжүүлэх	- 3.6
2. Зорилтот бүлэгт зээл олгох	- 2.5
3. Засгийн газраас хэрэгжүүлж буй арга хэмжээг хүн бүрт хүргэх	- 0.7
4. Зээлийн хүүг бууруулах, хугацааг сунгах	- 42.0
5. Зээлийн хэмжээг өсгөх	- 2.2
6. Зээлийн тэглэх	- 1.6
7. Зарим барааны үнийг бууруулах	- 3.4
8. Нарантуул захыг дотор оруулах	- 0.4
9. Ядуурлыг бууруулах	- 0.6
10. Вальютын ханшийг тогтворжуулах	- 1.1
11. Үндэсний үйлдвэрлэлээ дэмжих	- 1.3
12. ТҮЦ-ний цагийн хувиарыг уртасгах	- 0.2
13. Түрээсийн үнийг бууруулах	- 13.2
14. Торгууль, татварыг бууруулах	- 7.3
15. Үйл ажиллагаа явуулж буй орчинг сайжруулах	- 2.9
16. Хилээ нээх	- 1.9
17. ЖДҮ-ийг дэмжих зээл олгох	- 7.4
18. Ажлын байр бий болгох	- 2.9
19. Бизнес эрхлэгчдээ дэмжих	- 4.6
20. 7 хоногт 1 өдөр амардаг болох	- 0.2

Дээр тайлбарласанчлан иргэд зээлийн хүүг бууруулахад анхаарч өгөхийг асар ихээр хүсч байна. Зээлийн хүүг бууруулахыг хүссэн байдал бусад үзүүлэлтээс илүү өндөр байгааг харж болно. Хэдийгээр Засгийн газар, Монгол банкнаас зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгах шийдвэрийг гаргасан боловч энэ нь эргээд хувиараа хөдөлмөр эрхлэгсдэд эцсийн дүндээ дарамт болон хувирах магадлалтай. Учир нь зээлийн эргэн төлөлтийг сунгах нь төлөх хүүний хэмжээг улам бүр нэмэгдүүлж, хувиараа хөдөлмөр эрхлэгсдийн орлогыг улам бүр багасгах болно гэдгийг банкны зээлийн эдийн засагчид хэлж байна. Өөрөөр хэлбэл зээлийн эргэн төлөлтийн хугацааг уртасгах нь онцгой нөхцөл байдал дуустал бизнес

эрхлэгчдийн үйл ажиллагааг бүрмөсөн дампууруулахгүй авч үлдэх түр зуурын арга болохоос тэдэнд дэмжлэг үзүүлэх бодитой арга хэрэгсэл биш бололтой. Ялангуяа жижиг бизнес, хувиараа хөдөлмөр эрхлэгсдийн эргэлтэнд оруулах, барьцаа болгох хөрөнгө шавхагдах аваас нийгэмд ядуурал үлэмж хэмжээгээр нэмэгднэ. Хоёр жил тутамд Дэлхийн Банк болон Үндэсний статистикийн хороо Монгол Улсын ядуурлын хувь хэмжээг судалж зарладаг. Хамгийн сүүлд буюу 2018 онд танилцуулсан судалгаагаар Монголын хүн амын 28.4 хувь сарын 166 мянган төгрөгөөс бага хэрэглээтэй буюу ядуу гэдэг ангилалд багтаж байгааг танилцуулж байв. Энэ судалгааны үр дүнг танилцуулах үеэр дээрх 28.4 хувь буюу

904.9 мянган хүн дээр нэмэх нь нийт хүн амын 15% нь эмзэг байдалд байгааг онцолж байсан билээ. Улаанбаатар хотод 2018 оны байдлаар нийт ядуучуудын 41.8 хувь нь буюу 378.2 мянган хүн амьдарч байгааг Дэлхийн Банк танилцуулж байв. Гэтэл албан бус секторт ажиллагсадын 50

хувь Улаанбаатарт байгаа гэж хийсвэрээр тооцож үзвэл (ҮСХ-ны тооцоогоор 360 мянган хүн улсын хэмжээнд албан бус секторт ажиллаж байгаа гэсэн тооцоо бий) зээлийн эргэн төлөлт хийх чадваргүй болж байгаа 180 мянга орчим иргэн ядууралд автахад бэлэн болсон байна.

3.5 Иргэдийн Амьдралд Тулгарч буй Хүндрэл Бэрхшээл

ГРАФИК 3.18 СҮҮЛИЙН 5 САРЫН ХУГАЦААНД ӨРХИЙН АМЬЖИРГААНД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ




ГРАФИК 3.19 КОРОНАВИРУС ЦАР ТАХЛЫН НӨХЦӨЛ БАЙДЛААС ШАЛТГААЛАН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРЭН ЗОГССОНТОЙ ХОЛБОГДУУЛАН АЖИЛ ЭРХЛЭГЧДЭД ҮҮСЧ БУЙ АЧААЛАЛ, ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ ЯМАР БАЙНА ВЭ?



АСУУЛТ №10 СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БҮРЭН ЗОГССОН УЧИР ХҮҮХДИЙГ ХЭН ХАРЖ БАЙГАА

1. Эмээ, өвөө нь	- 28.1
2. Ах, эгч нь	- 25.0
3. Нөхөр (эхнэр)-тэйгээ ээлжилж харж байна	- 11.2
4. Хамаатны хүмүүс	- 4.9
5. Хажуу айлын хүмүүс	- 2.9
6. Хөдөө явуулсан	- 6.6
7. Хүүхэд харах хүн байхгүй ажлаа хийж чадахгүй байна	- 6.2
8. Өөр ямар: (Хүүхэд асрагч, ажил дээрээ авч ирдэг, олдсон хүндээ харуулдаг)	- 15.1

3.6 Судалгаанд оролцогчдын Ерөнхий мэдээлэл

ЗУРАГ 3.1 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН ХҮЙС



ГРАФИК 3.20 СУДАЛГААНД ОРОЛЦОГЧДЫН НАС





ГРАФИК 3.21 БОЛОВСРОЛЫН ТҮВШИН



ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Төрөөс авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний тухай:

БНХАУ-ын Хубэй мужийн Вухан хотод онош нь үл мэдэгдэх уушгины хатгалгаа гарсан нь ДЭМБ-ын Хятад улс дахь салбарт 2019 оны 12-р сарын 31-нд анх мэдээлснээс сарын дараа Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл 2020 оны 1 сарын 30-ны өдөр хуралдаж, 01/01 дугаартай "Хилийн боомтыг түр хаах тухай" зөвлөмж гаргасан. 2020 оны 2 сарын 1-ний өдрөөс өнөөг хүртэл үе шаттайгаар Монгол Улсын иргэд БНХАУ-д зорчихыг хориглосон. Хорио цээрийн хугацаанд БНХАУ-аас орж ирэх бараа таваарын импорт, экспортыг хязгаарлаагүй байна. Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 4 сарын 29-ний өдөр "Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай" коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахал (цаашид "цар тахал" гэх)-аас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгмийн эрүүл мэндийг хамгаалах, хүний эрхэд тодорхой хязгаарлалт хийх, холбогдох шийдвэрийг шуурхай гаргах, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, зохион байгуулалтын асуудлыг Засгийн газар онцгой журмаар шийдвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий хуулийг баталсан. Үүний дагуу Засгийн газраас Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахлын үед иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх арга хэмжээнүүдийг аван ажиллаж байна.

Судалгаанаас гарсан дүгнэлт: Монгол Улсад албан бус секторт 360 мянга орчим

хүн ажилладаг гэсэн албан бус мэдээ байдаг бөгөөд эдгээрийн дийлэнх нь Улаанбаатар хотод 11 мянга орчим цэгт үйл ажиллагаа явуулдаг.

Албан бус секторт ажиллагсдын 30.9 хувь нь эрэгтэй, 69.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Гэвч судалгаагаар эмэгтэйчүүд 3-аас дээш жил ажиллах нь бага, тогтвортой ажиллах нөхцөл бүрдээгүй ажээ.

Мөн урьд өмнөх судалгаануудтай харьцуулж үзвэл ажлын байрны нөхцөл харьцангуй сайжирч байна гэж үзэж болохоор дүр зураг харагдаж байна. Судалгаанд хамрагдагсдын 77.9 хувь нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа нь тэдний үйл ажиллагаа үл хөдлөх хөрөнгийн зах зээл, томоохон түрээслэгч аж ахуйн нэгжүүдээс ихээхэн хамааралтай байдаг гэж үзэж болно. Харин COVID-19-ийн нөхцөл байдлаас хамааран түрээсийн төлбөр 10 хувь буурсан нь 12 хувь, 20 хувь хүртэл буурсан 30 орчим хувь (дунджаар 100-200 мянган төгрөг) байгаа үзүүлэлттэй байна. Гэвч ярилцлагын явцад түрээсийн төлбөр бодит байдлаар буураагүй байж магадгүй байдал ажиглагдсан. Учир нь томоохон аж ахуйн нэгжүүд татварын хөнгөлөлт эдлэхийн тулд түрээсийн гэрээг бууруулсан болгож харагдуулах зарим нэгэн үйлдлүүдийг хийж байгаа бололтой. Цар тахлын хөл хорио тогтоохоос өмнө 1-3 сая төгрөг хүртэлх орлоготой иргэд 43.5 хувь байсан бол хөл хорио тогтоосноос хойш тэдний хэмжээ эрс буурч 18.3 хувь болж **2.3 дахин**, 3-5 саяын орлоготой иргэдийн тоо 10.3 хувиас 3.3 хувь буюу **3 дахин**, 5 саяас дээш орлоготой иргэд 13,9 хувь байсан нь 3.2 хувь хүртлээ буюу **4 дахин** буурсан байна. Өөрөөр хэлбэл борлуулалтын орлого өндөр байсан иргэд

энэхүү нөхцөлд нэрвэгдэх магадлал илүү их байгаа юм.

Судалгаанд хамрагдагсдын 28.3 хувь нь худалдан авалт бага зэрэг буурсан, 62.7 хувь нь худалдан авалт эрс муудсан гэж хариулсан. Борлуулалт эрс муудсан хэсэгт гол төлөв хүнсний бөөний худалдаа, хувцас засвараас бусад салбар орж байна.

Өмнөх оны мөн үед Монгол Улсын хэмжээнд чанаргүй зээлийн эзлэх хувь 10.6 хувь, хугацаа хэтэрсэн зээл 4.8 хувь, банкны үзүүлэлтээр чанаргүй зээл 8.7 хувь, хугацаа хэтэрсэн зээл 4.9 хувь байжээ. Харин энэ судалгаанд хамрагдсан иргэдийн хариултаас харахад өнөөгийн байдлаар хувиараа хөдөлмөр эрхлэгчдийн 29.5 хувь нь хугацаа хэтэрсэн зээлтэй, 16.2 хувь нь чанаргүй зээлдэгч болсон гэж байгаа нь өмнөх оны улсын дунджаас хэд дахин давсан үзүүлэлт болон харагдаж байна. Банкны зээлийн хүү нь Ковид-19-ийн нөхцөлд жижиг бизнес эрхлэгчдэд улам их дарамт болж байна.

МУ-ын Засгийн газраас авч хэрэгжүүлж буй хүүхдэд олгох мөнгө, тэтгэвэр, тэтгэмж зэрэг нь олон хүүхэдтэй болон тогтмол орлоготой иргэдэд ихээхэн дэмжлэг үзүүлж байгаа хэдий ч татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт зэрэг нь хувиараа хөдөлмөр эрхлэгсдэд төдийлөн тусламж болж чадахгүй байна (Угаас 40 гаруй хувь нь нийгмийн даатгалын шимтгэл, албан татвар төлдөггүй). Тогтмол бус, зөвхөн өөрийн үйл ажиллагаанаас өөр орлогогүй иргэдийн нөхцөл байдал илүү хүндрэх, ядуурлын улаан шугамыг давах төлөвтэй болжээ.

Хөл хорионы онцгой нөхцөл байдалд дээрх иргэдийн 55 хувийн орлого буурсан, 30 хувийн орлого эрс буурсан, 24 хувийнх нь өрхийн зарлага эрс нэмэгджээ. Үүнээс гадна сургууль цэцэрлэгийн үйл ажиллагаа зогссоноос үүдэн 40 гаруй хувь нь хүүхэдтэй холбоотой ямар нэгэн хүндрэлийг туулж байна.

ТАВ. ЗӨВЛӨМЖ

Төрөөс орлого нь тодорхойгүй, тогтмол бус орлоготой хэсэгт тусгайлан анхаарсан бодлого явуулах хэрэгтэй болжээ. Төрийн албан хаагчид, тэтгэвэр тэтгэмж хүртэгсдийн орлого нэмэгдсэн албан ёсны тоо байгаа ч ачааны хүндийг үүрдэг тэр л дундаж хэсэг өнөөгийн нөхцөлд хамгийн ихээр нэрвэгдэж эхэллээ. Энэ нь цаашид жижиг дунд бизнесийн салбар бүхэлдээ нуран унах, ядуурлын төвшинг огцом нэмэгдүүлэх аюултай юм. *(Олон улсад нийгэм, макро эдийн засгийг бүхэлд нь бус сегментчилэн харж ажиллах зөвлөмжийг өгөх болсон)*

- Хилийн хорио тогтоосноос улбаалан иргэд өөрсдийн биеэр бараа таваараа сонгох, хэмжээ чанарт хяналт тавих, тээвэрлэлтэд нөлөөлөх боломжгүй байна. Ялангуяа жижиг бизнес эрхлэгчдэд чанаргүй бараа нийлүүлэгдэх, хэмжээ дутах, тээвэрлэлтийн хугацаа алдах зэрэг нь алдагдал хүлээх том шалтгаан болж байгаа юм. Ийм учир нийлүүлэгч талын (хувиараа хөдөлмөрлөгчдийн 70 гаруй хувь нь БНХАУ-аас бараа, бүтээгдэхүүнээ авдаг) төрийн байгууллагуудтай хамтран ажиллах, иргэдийнхээ худалдан авсан бараа, бүтээгдэхүүний чанар хэмжээнд хяналт тавьж, эрхийг нь хамгаалах, ачаа тээврийн үйлчилгээг шуурхайлуулах, зохион байгуулах арга хэмжээг авах,
- Түрээслэгчдийн эрхийг хамгаалах. Дийлэнх хувиараа хөдөлмөр эрхлэгсдийн орлого нь МУ-ын цалингийн дунджийн хэмжээнд байгаа. Гэтэл энэхүү орлогоо бараа бүтээгдэхүүнээ худалдан авах, түрээс төлөхөд голлон зарцуулдаг,

бодит орлого нь өчүүхэн бага. Томоохон түрээслүүлэгч аж ахуйн нэгжүүд байрлал зэрэг хүчин зүйлээс хамааруулан төлбөрийн хэмжээг дураараа тогтоодог, өрсөлдөөн байдаггүй зэрэг нь иргэдэд ихээхэн хүндрэлийг үүсгэж байна. Иймээс түрээслүүлэгч байгууллагууд, объектын судалгааг бүрэн гаргаж, төлбөрийн хэмжээг индексжүүлэх, түрээсийн байранд тавигдах эрүүл ахуй, стандартын шаардлагуудыг эхэлж мөрдүүлэх (Түрээслэгч өөрөө тохижилтыг хариуцах нь элбэг байна). Түрээслэгчдийн эрхийг хамгаалах үйлдвэрчний эвлэлийн байгууллагуудыг бий болгох,

- Зээлийн хүүг бууруулах. Хувиараа хөдөлмөр эрхлэгсдийн банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүг бууруулах, гэрээнд өөрчлөлт оруулах ажилд хяналт тавих, олон нийтэд сурталчлах. Иргэд хэдийгээр төлбөрийн чадвар муудсаны улмаас зээлийн эргэн төлөлтийн хугацааг сунгуулахаар хүсэлтээ өгөх хандлага нэмэгдсэн байгаа ч төрөөс энэ талаар авч буй арга хэмжээний талаар мэдээлэл муутай байна. Нэгэнт авсан зээлийн хүүг бууруулах талаар ч хөөцөлдөх явдал бага байгаа юм. Хугацаагаа л сунгуулж чадвал хүү ч яамай гэх хандлага их байна.
- Хувиараа хөдөлмөр эрхлэгсдийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтөд төрөөс анхаарсан бодлого явуулах. Албан бус секторт ажиллагсад нь 1-рт орлого багатайгаас, 2-рт албан татвар төлдөггүйгээс хамааран нийгмийн даатгалын шимтгэл төлж

чадахгүй байна (Татварын өрөнд орж магад хэмээн тодорхой хэмжээний айдастай байдаг). Чухамхүү ямар нэгэн байдлаар төрийн бүртгэлд хамрагдахгүй байгаагаас хөнгөлөлт, чөлөөлөлт, нэмэгдэл, урамшуулалд хамрагдаж чадахгүй байгаа билээ. Ялангуяа өрхийн бизнест цалин хөлсгүй оролцогчдын ихэнх нь буюу 61.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байгаа нь энэ талаар шийдвэртэй арга хэмжээ авах, тэднийг ядуурлаас хамгаалах бодлого тууштай хэрэгжүүлэх цаг болсны харуулж байна. Өнөөг хүртэл албан бус секторт ажиллагсдын талаар ямар нэгэн судалгаа, албан ёсны бүртгэл байхгүй байгаа.

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл хөтөлбөр, хөрөнгө оруулалтуудыг онцгой нөхцөл байдал өнгөртөл хязгаарлахгүй, багасгахгүй байх, сахилга батыг сайжруулах бодлогыг баримтлах. Үйлчилгээний

салбарын бага бус хувь нь төсвийн хөрөнгө оруулалт, худалдан авалтад тулгуурлан амь зогоож байна. Цаашид жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын бүтцийг авч үлдэх нь нийгмийн дундаж давхаргыг хамгаалах, монополь өрсөлдөөнийг хязгаарлах сайн талтай юм.

- Хөл хорионы нөхцөлд хамгийн ихээр хэлмэгдэж буй салбарыг тодорхойлон, цаашид авах арга хэмжээгээ боловсруулах. Жишээлбэл аялал жуулчлалын салбар, түүнийг дагасан ханган нийлүүлэлтийн сүлжээ, хоол боловсруулах, бэлтгэх гм.
- Орчин үеийн цахим сүлжээ, технологийг ашиглан үйлчилгээг түргэн шуурхай, зардал багатай болгох тал дээр иргэдийг сургах, үйлчилгээний шинэ хэлбэрийг нэвтрүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх.

ХАВСРАЛТУУД

ХАРЬЦУУЛСАН ДҮН (ДҮҮРГЭЭР)

Үйл ажиллагаа эрхлэн явуулж буй чиглэлүүдийн орчны стандарт, шаардлага хангаж чадаж байгаа эсэхийг харьцуулбал:

(Мөрөөр хөөж харах – 100%)

№		Бүрэн хангасан	Зарим зүйлс нь хангагдаагүй	Огт хангагдаагүй
1	ТҮЦ	47.1	47.1	5.7
2	Гутал, хувцас засвар	60.0	33.3	6.7
3	Авто засвар	69.6	28.3	2.2
4	Дугуй засвар	78.3	17.4	4.3
5	Авто машины угаалга	80.0	20.0	---
6	Жижиглэн худалдааны цэг	40.6	50.0	9.4
7	Хүнсний чингэлэг	53.6	43.6	2.8
8	Хүнсний бус чингэлэг	59.3	35.2	5.6
9	Лангуу	46.1	47.1	6.8
10	Дэлгүүр	64.1	32.4	3.5

Харьцуулалт №2

Үйл ажиллагаа эрхлэн явуулж буй чиглэлүүдийн түрээсийн үнийг харьцуулбал:

(Мөрөөр хөөж харах – 100%)

№		500.000 Доош	500.000 - 1.000.000	1.000.000- 3.000.000	3.000.000- 5.000.000	5.000.000- 10.000.000 хүртэлх
1	ТҮЦ	44.6	53.6	1.8	---	---
2	Гутал, хувцас засвар	75.0	20.0	2.5	---	2.5
3	Авто засвар	39.3	57.1	3.6	---	---
4	Дугуй засвар	66.7	26.7	6.7	---	---
5	Авто машины угаалга	---	78.6	21.4	---	---
6	Жижиглэн худалдааны цэг	50.0	40.9	9.1	---	---
7	Хүнсний чингэлэг	44.9	44.2	10.9	---	---
8	Хүнсний бус чингэлэг	37.0	56.5	6.5	---	---
9	Лангуу	47.1	39.6	12.9	0.3	---
10	Дэлгүүр	40.4	49.5	10.1	---	---

Харьцуулалт №3

Үйл ажиллагаа эрхлэн явуулж буй чиглэлүүд тус бүрээр коронавирус цар тахал гарснаас хойш түрээсийн зардлыг бууруулсан эсэхийг харьцуулбал:

(Мөрөөр хөөж харах – 100%)

№		Ямарч өөрчлөлт гараагүй	Тодорхой хэмжээгээр бууруулсан
1	ТҮЦ	49.3	50.7
2	Гутал, хувцас засвар	55.6	44.4
3	Авто засвар	51.5	48.5
4	Дугуй засвар	46.7	53.3
5	Авто машины угаалга	50.0	50.0
6	Жижиглэн худалдааны цэг	37.0	63.0
7	Хүнсний чингэлэг	34.7	65.3
8	Хүнсний бус чингэлэг	54.3	45.7
9	Лангуу	35.5	64.5
10	Дэлгүүр	48.4	51.6

Харьцуулалт №4

Бичил бизнес эрхлэгчдийг хүйсээр нь харьцуулбал:

(Мөрөөр хөөж харах – 100%)

№		Эрэгтэй	Эмэгтэй
1	ТҮЦ	23.6	76.4
2	Гутал, хувцас засвар	36.8	63.2
3	Авто засвар	80.0	20.0
4	Дугуй засвар	70.8	29.2
5	Авто машины угаалга	66.7	33.3
6	Жижиглэн худалдааны цэг	23.3	76.7
7	Хүнсний чингэлэг	25.6	74.4
8	Хүнсний бус чингэлэг	27.8	72.2
9	Лангуу	27.3	72.7
10	Дэлгүүр	24.4	75.6

Харьцуулалт №5

Бичил бизнес эрхлэгчдийг Нийгмийн даатгалд хамрагддаг эсэхийг хүйсээр нь харьцуулбал:

(Мөрөөр хөөж харах – 100%)

№		Эрэгтэй	Эмэгтэй
1	Нийгмийн даатгал төлдөг	34.2	65.8
2	Нийгмийн даатгал төлдөггүй	27.1	72.9

Харьцуулалт №6

Бичил бизнес эрхлэгчдийг Хүн амын орлогын албан татвар төлдөг эсэхийг хүйсээр нь харьцуулбал:

(Мөрөөр хөөж харах – 100%)

№		Эрэгтэй	Эмэгтэй
1	ХАОАТ төлдөг	34.0	66.0
2	ХАОАТ төлдөггүй	27.5	72.5

Харьцуулалт №7

Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанууд бичил бизнес эрхлэгчдийн амьдралд хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг хүйсээр нь харьцуулбал:

(Мөрөөр хөөж харах – 100%)

№		Эрэгтэй	Эмэгтэй
1	0-18 насны хүүхэд бүрт 4 сарын 1-ээс 10 сарын 1-ний өдөр хүртэл хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100.000 болгосон.	30.1	69.9
2	Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн хүнсний талоныг хоёр дахин нэмэгдүүлсэн	28.1	71.9
3	Нийгмийн халамжийн сангаас сар бүр дараах иргэдэд олгодог 188 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 5 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд тус бүр 100.000 төгрөгөөр нэмэгдүүлсэн	23.9	76.1
4	Бүх Аж ахуй нэгжийг нийгмийн даатгалын 26 хувийн шийтгэлээс 6 сар чөлөөлсөн	32.9	67.1
5	Иргэдийн цалин хөлснөөс 6 сар орлогын албан татвар авахааргүй болсон.	40.0	60.0

6	1.5 тэрбумаас доош орлоготой Аж ахуй нэгжүүдээс 6 сар ААНОАТ авахгүй болсон	38.0	62.0
7	Шатахууны үнийг литр тутамд 300-400 төгрөгөөр бууруулсан	31.6	68.4
8	Ажлын байраа хадгалсан хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн ажилтан бүрт 3 сарын хугацаанд сар бүр 200.000 төгрөгийн дэмжлэг үзүүлнэ	25.9	74.1
9	Ипотекийн зээлтэй иргэдийн зээлийн төлөлтийг хойшлуулсан	30.9	69.1
10	Малчдын орлого болон ноолуурын салбарын дотоод үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ноолуурын кг тутамд 20,000 төгрөгийн урамшуулал олгох болсон.	20.6	79.4

Харьцуулалт №8

Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагаанууд бичил бизнес эрхлэгчдийн амьдралд хэрхэн нөлөөлж байгаа эсэхийг насаар нь харьцуулбал:

(Мөрөөр хөөж харах – 100%)


№		21-25	26-30	31-35	36-40	41-45	46-50	51-55	56-60	61-ээс дээш
1	0-18 насны хүүхэд бүрт 4 сарын 1-ээс 10 сарын 1-ний өдөр хүртэл хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100.000 болгосон.	8.8	12.7	17.5	25.2	14.5	8.5	7.3	3.5	2.0
2	Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн хүнсний талоныг хоёр дахин нэмэгдүүлсэн	7.2	12.7	16.6	24.3	13.8	7.7	7.7	6.1	3.9
3	Нийгмийн халамжийн сангаас сар бүр дараах иргэдэд олгодог 188 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 5 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд тус бүр 100.000 төгрөгөөр нэмэгдүүлсэн	8.7	13.1	20.4	23.5	12.5	6.2	6.2	5.5	3.8
4	Бүх Аж ахуй нэгжийг нийгмийн даатгалын 26 хувийн шийтгэлээс 6 сар чөлөөлсөн	11.2	13.6	14.5	24.9	15.1	8.9	8.0	1.8	2.1
5	Иргэдийн цалин хөлснөөс 6 сар орлогын албан татвар авахааргүй болсон.	9.2	13.8	15.4	26.2	18.5	6.9	3.1	3.8	3.1
6	1.5 тэрбумаас доош орлоготой Аж ахуй нэгжүүдээс 6 сар ААНОАТ авахгүй болсон	9.1	19.1	12.7	19.1	19.1	7.3	6.4	2.7	4.5
7	Шатахууны үнийг литр тутамд 300-400 төгрөгөөр бууруулсан	7.3	13.3	15.5	26.5	14.0	9.7	9.0	3.2	1.5
8	Ажлын байраа хадгалсан хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн ажилтан бүрт 3 сарын хугацаанд сар бүр 200.000 төгрөгийн дэмжлэг үзүүлнэ	17.2	12.1	17.2	31.0	6.9	6.9	5.2	1.7	1.7
9	Ипотекийн зээлтэй иргэдийн зээлийн төлөлтийг хойшлуулсан	8.7	13.3	18.9	29.1	13.3	8.7	3.1	3.6	1.5
10	Малчдын орлого болон ноолуурын салбарын дотоод үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ноолуурын кг тутамд 20,000 төгрөгийн урамшуулал олгох болсон.	14.3	11.4	22.9	25.7	11.4	2.9	5.7	2.9	2.9

БАЯНГОЛ ДҮҮРЭГ


НЭГ. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙН ОРЧИН НӨХЦӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

1. Таны үйл ажиллагаа явуулж байгаа байршил: БАЯНГОЛ ДҮҮРЭГ


2. Та ямар чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байна вэ?



3. Та үйл ажиллагаагаа эрхлээд хэдэн жил болж байна вэ?




4. Таны үйл ажиллагаа эрхлэн явуулж буй газар орчны шаардлага, стандартыг бүрэн хангасан уу?




5. Орчны шаардлага, стандарт бүрэн хангагдаагүй бол ямар асуудлууд гардаг вэ?

- | | |
|---|--------|
| 1. Машины зогсоол, талбайн асуудлыг шийдэх | - 1.5 |
| 2. Засвар үйлчилгээ хийх, орчны тохижилтод анхаарах | - 21.2 |
| 3. Тоос, шороо их | - 1.5 |
| 4. Өвөл халаалт муу | - 12.1 |
| 5. Нарануул захыг байранд оруулах | - 1.5 |
| 6. Явган хүний зам | - 1.5 |
| 7. Ус зайлуулах хоолой байхгүй | - 3.0 |
| 8. Ариун цэврийн өрөө | - 1.5 |
| 9. Ус их нэвтэрдэг | - 10.6 |
| 10. Стандартын бус барилга (цонх байхгүй) | - 4.5 |
| 11. Цахилгаан байнга тасардаг | - 1.5 |
| 12. Торгууль, татварын асуудал | - 1.5 |
| 13. Хүнсний бохирдол | - 1.5 |
| 14. Хогны асуудал | - 1.5 |
| 15. Эрүүл ахуйн орчин | - 3.0 |
| 16. Агааржуулалт муу | - 31.8 |


6. Та үйл ажиллагаа явуулдаг газраа түрээсэлдэг үү?



7. Та хэдэн төгрөгөөр түрээсэлдэг вэ?



8. Коронавирус гарснаас хойш түрээсийн зардлыг ямар нэгэн байдлаар бууруулсан уу?



Бууруулсан үнийн дүн

1.	900.000-1.000.000₮	- 1.3
2.	500.000-600.000₮	- 2.7
3.	50%	- 1.3
4.	40%	- 1.3
5.	30%	- 8.0
6.	20%	- 56.0
7.	15%	- 13.3
8.	10%	- 16.0

ХОЁР. БИЧИЛ БИЗНЕС ЭРХЛЭГЧИЙН ОРЛОГО

9. Таны сарын орлого?

1.	900.000-1.000.000	16.9	5.	5.000.001-ээс дээш	- 7.7
2.	500.000-900.000	- 19.2	6.	300.000-500.001	- 1.5
3.	1.000.001-3.000.000	- 44.6	7.	100.001-300.001	- 1.5
4.	3.000.001-5.000.000	- 7.7	8.	100.000 хүртэлх	- 0.8

10. Коронавирус гарахаас өмнө ба дараа Таны сарын орлогод ямар өөрчлөлт гарсан бэ?

Коронавирус гарахаас өмнө:

1.	500.000-900.000	- 16.5
2.	1.000.001-3.000.000	- 13.9

3.	3.000.001-5.000.000	- 39.1
4.	5.000.001-ээс дээш	- 10.4
5.	300.000-500.001	- 17.4
6.	100.001-300.001	- 1.7
7.	100.000 хүртэлх	- 0.9

Коронавирус гарсны дараа:

1.	Орлого эрс муудсан	- 11.4
2.	900.000-1.000.000	- 18.9
3.	500.000-900.000	- 20.5
4.	1.000.001-3.000.000	- 20.5
5.	3.000.001-5.000.000	- 4.5
6.	5.000.001-ээс дээш	- 3.8
7.	300.000-500.001	- 6.8
8.	100.001-300.001	- 2.3
9.	100.000 хүртэлх	- 2.3
10.	40-50% буурсан	- 5.3
11.	30% буурсан	- 2.3
12.	15-20% буурсан	- 0.8
13.	10% буурсан	- 0.8


11. Коронавирус цар тахал гарснаас хойш иргэдийн худалдан авах чадварт ямар нөлөө гарсан бэ?



12. Коронавирус цар тахлаас үүдэн Монгол улсын Засгийн газраас өндөржүүлсэн байдалд шилжсэнтэй холбогдуулан Монгол улс өөрийн бүх хилээ хаасан. Үүнтэй холбоотой таны эрхэлж байгаа бизнесийн үйл ажиллагаанд ямар хүндрэл бэрхшээл учирч байна вэ?



13. Та өөрийн бүтээгдэхүүнийхээ нийлүүлтээ хаанаас хийдэг вэ?



Бараа авдаг улс:

- | | |
|-------------|--------|
| 1. БНХАУ | - 82.8 |
| 2. ОХУ | - 13.8 |
| 3. Солонгос | - 3.4 |


14. Гадаад улс орноос бараа бүтээгдэхүүн авдаг бол ямар хүндрэл бэрхшээл тулгарч байна вэ?

1. Зарим нэр төрлийн барааг хилээр нэвтрүүлэхгүй байна	- 2.6
2. Бараа тасарсан	- 15.8
3. Валютын ханшны хэлбэлзэл	- 3.9
4. Захиалсан бараа дутуу, жин хэмжээндээ хүрэхгүй байгаа	- 7.9
5. Захиалгын барааны чанар муу, сонголт хийж чадахгүй байна	- 11.8
6. Хугацаа маш их алдаж ирдэг, тээвэрлэлт удаан	- 22.4
7. Үнийн өсөлт	- 9.2
8. Татварын үнэ нэмэгдсэн	- 5.3
9. Хилээ нээх	- 5.3
10. Хил хаасан	- 10.5
11. Гаалийн татвар өндөр	- 5.3


15. Коронавирус гарснаас хойш барааны төрөл, зүйлд өөрчлөлт орсон уу?




16. Та нийгмийн даатгал төлдөг үү?



17. Та хүн амын орлогын албан татвар төлдөг үү?




18. Та бизнесийнхээ үйл ажиллагаанд зарцуулах гэж зээл авсан уу?



19. Та зээлтэй бол хэзээ авсан бэ?

1.	2019 он	- 31.6
2.	2020 он	- 19.7
3.	2018 он	- 18.4
4.	2017 он	- 7.9
5.	2016 он	- 7.9
6.	2015 он	- 5.3
7.	2014 он	- 1.3
8.	2013 он	- 1.3
9.	2010 он	- 6.6


20. Та хаанаас зээл авсан бэ?



Банкны нэр:


1. Голомт банк	- 22.6
2. Төрийн банк	- 8.1
3. Худалдаа хөгжлийн банк	- 12.9
4. Хас банк	- 12.9
5. Хаан банк	- 41.9
6. Богд банк	- 1.6

21. Таны бизнесийн үйл ажиллагааны санхүү, зээлийн эргэн төлөлттэй холбоотой ямар хүндрэл бэрхшээл байна вэ?



ГУРАВ. ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ БОДЛОГО ШИЙДВЭР

22. Монгол Улсын Засгийн газраас Коронавирус цар тахлаас шалтгаалан эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг арилгах, даван туулахын тулд авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ хэр үр дүнтэй байна вэ?



23. Засгийн газраас хэрэгжүүлж буй дараах үйл ажиллагаануудаас хамгийн оновчтой гэсэн шийдвэрүүдийг сонгоно уу?

№	Засгийн газраас хэрэгжүүлж буй ажлууд	Тоо	Хувь
1	0-18 насны хүүхэд бүрт 4 сарын 1-ээс 10 сарын 1-ний өдөр хүртэл хүүхдийн мөнгөн тэтгэмжийг 100.000 болгосон.	147	33.9%
2	Хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн хүнсний талоныг хоёр дахин нэмэгдүүлсэн	33	7.6%
3	Нийгмийн халамжийн сангаас сар бүр дараах иргэдэд олгодог 188 мянган төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг 5 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд тус бүр 100.000 төгрөгөөр нэмэгдүүлсэн	45	10.4%
4	Бүх Аж ахуй нэгжийг нийгмийн даатгалын 26 хувийн шийтгэлээс 6 сар чөлөөлсөн	48	11.1%
5	Иргэдийн цалин хөлснөөс 6 сар орлогын албан татвар авахааргүй болсон.	17	3.9%
6	1.5 тэрбумаас доош орлоготой Аж ахуй нэгжүүдээс 6 сар ААНОАТ авахгүй болсон	5	1.2%
7	Шатахууны үнийг литр тутамд 300-400 төгрөгөөр бууруулсан	106	24.4%
8	Ажлын байраа хадгалсан хувийн хэвшлийн аж ахуй нэгжийн ажилтан бүрт 3 сарын хугацаанд сар бүр 200.000 төгрөгийн дэмжлэг үзүүлнэ	5	1.2%


9	Ипотекийн зээлтэй иргэдийн зээлийн төлөлтийг хойшлуулсан	25	5.8%
10	Малчдын орлого болон ноолуурын салбарын дотоод үйлдвэрлэлийг дэмжих зорилгоор ноолуурын кг тутамд 20,000 төгрөгийн урамшуулал олгох болсон.	3	0.7%

24. Засгийн газраас бичил бизнес эрхлэгчийн үйл ажиллагааг дэмжихэд ямар ажил, арга хэмжээг аваасай гэж Та хүсч байна вэ?


1. Зөв бодлого хэрэгжүүлэх	- 2.1
2. Зорилтот бүлэгт зээл олгох	- 2.8
3. Зээлийн хүүг бууруулах, хугацааг сунгах	- 42.7
4. Зээлийн хэмжээг өсгөх	- 1.4
5. Зээлийн тэглэх	- 0.7
6. Зарим барааны үнийг бууруулах	- 4.2
7. Вальютын ханшийг тогтворжуулах	- 2.1
8. Түрээсийн үнийг бууруулах	- 14.7
9. Торгууль, татварыг бууруулах	- 11.2
10. Хилээ нээх	- 2.1
11. ЖДҮ-ийг дэмжих зээл олгох	- 8.4
12. Ажлын байр бий болгох	- 0.7
13. Бизнес эрхлэгчдээ дэмжих	- 0.7
14. 7 хоногт 1 өдөр амардаг болох	- 1.4

ДӨРӨВ. ИРГЭДИЙН АМЬДРАЛД ТУЛГАРЧ БУЙ ХҮНДРЭЛ БЭРХШЭЭЛ

25. Сүүлийн 5 сарын хугацаанд танай өрхийн амьжиргаанд хэр өөрчлөлт гарсан бэ?



26. Коронавирус цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагаа бүрэн зогссонтой холбогдуулан ажил эрхлэгчдэд үүсч буй ачаалал, хүндрэл бэрхшээл ямар байна вэ?



